МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,162.969... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.09.11. Даваа. №153 (4767) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**



Өдөр +20
Шөнө +4

**ДЭЛХИЙ**

"ИРМА" ХАР САЛХИ ФЛОРИДАГ ДАЙРЛАА

IV нүүрт

**ОНЦЛОХ ХУУДАС**

ОФФШОР ДАНСТНУУДАД ӨГСӨН 49 ХОНОГИЙН ХУГАЦАА ДУУСЛАА

V нүүрт

Дугаарын 60 мөр

## Нэртэйгээр нь Монгол нэрээ, "Орк"-оор сольчих

Б.ДАВАА

Хэзээ, хэн нэвтрүүлсэн нь үл мэдэгдэх "Орк" гэх үг нийгэмд хуурай өвсөнд тавьсан түймэр мэт өргөн хэрэглэгдэх болжээ. Эхэндээ хотын төвд, хэнэг ч үгүй "морь харах" залуус, нус цэрээ хаа тааралдсан газраа хаях бүдүүлэг нэгэн, замын хөдөлгөөний наад захын дүрмийн мэдлэггүй жолооч, суурин соёлд төдийлөн дасч чадаагүй хүмүүсийг "Орк" гэж нэрлэдэг байв.

Харин одоо үгийнх нь утга улам бүр өргөжиж, өөрт нь таалагдахгүй үйлдэл гаргасан хүн бүр өнөөх "Орк" гэх нэрээр дуудуулах болж. Тэр бүү хэл ард түмний дэмжлэгээр төр түшилцэхээр сонгогдсон гишүүд хүртэл иргэдээ орк хэмээн доромжилж байх вэ дээ.

**Үргэлжлэл нь III нүүрт**



# МОРДОХЫН ХАЗГАЙ

Б.СЭМҮҮН

УИХ-д үнэмлэхүй ялалт байгуулж, 65 суудалтай бүлэг байгуулсан МАН сонгуулийн үр дүнгээр байгуулсан Засгийн газраа 14 сарын дараа өөрсдийн гараар буулгалаа. Засгийн газрыг огцруулсан ээлжит бус чуулган дээр гишүүн Ц.Нямдоржийн "Ц.Элбэгдорж гэдэг хүн АН-аар тоглож дуусаад одоо МАН-аар тоглож байна" гэсэн нь үнэндээ бол домог юм. Харин 65 гишүүний эрх ашиг, шунал хүслийг нэг байтугай Засгийн газар хангаж чадахгүй нь бол ялалт ч үгүй үнэн. Үгүй ядаж л 800 тэрбумын концессийг долоохон компани хуваагаад авчихаар арга байж уу. Ингээд Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа эхэлсэн Засгийн газрыг огцруулах ажиллагаа амжилттай болж, МАН-ын хоёр дахь ээлж хоолондоо орохоор халбага, сэрээгээ хангинуулаад эхэллээ. Одоо засгийн эрх мэдэл хэнд шилжих вэ?

**Үргэлжлэл нь III нүүрт**

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## Монгол Улсын Ерөнхийлөгч хэлмэгдэгсдийн ар гэрийнхнээс уучлал хүслээ

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга улс төрийн хэлмэгдэгсэд болон тэдний гэр бүл, төрөл төрөгсдөөс өчигдөр төрийн нэрийн өмнөөс уучлал хүслээ. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг жил бүрийн есдүгээр сарын 10-нд хүндэтгэн дурсдаг юм. Монгол Улсад улс төрийн хилс хэргээр олон мянган хүнийг хоморголон хэлмэгдүүлсэн хар үйл явдлаас хойш 80 дахь жил энэ онд тохиож байна. Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, УИХ-ын дарга М.Энхболд, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Я.Санжмятав болон хэлмэгдэгсдийг дурсан санаж, хүндэтгэл үзүүлэхээр ирсэн УИХ-ын зарим гишүүд, Улс төрийн намууд, Төрийн болон төрийн бус байгууллага, ард иргэдийн төлөөлөл Хэлмэгдэгсдийн хөшөөнд цэцэг өргөлөө. Цэцэг өргөх ёслолын дараа Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга улс төрийн хэлмэгдэгсэд, тэдний гэр бүл, төрөл төрөгсдөөс нь Монголын төрийн нэрийн өмнөөс уучлал хүсч үг хэлсэн юм. Тэрбээр "Монголчууд аа, эрхэм төрийн түшээд, энд хүрэлцэн ирсэн улс төрийн намуудын удирдлагууд аа, хатагтай, ноёд оо. Та бид 80 жилийн өмнөх хэзээ ч мартаж болохгүй хар өдрийг нэхэн санаж, улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэхийн зэрэгцээ түүхэн, гашуун сургамжийг төрийн ой санамжид баттай суулгаж, иргэний эрх, эрх чөлөөг ямагт сахин хамгаалах Төрийн дархлааг нь бэхжүүлэхийн чухлыг ахин эргэцүүлэхийн тулд энд хуран цуглаад байгаа билээ.

**Үргэлжлэл нь II нүүрт**





ХААН БАНК
MIAT MONGOLIAN AIRLINES




**МИЛЬ ХУРИМТЛУУЛАХ ХАМТАРСАН ХӨТӨЛБӨР ЭХЛҮҮЛЛЭЭ**

Монгол Улсын тэргүүлэгч ХААН Банк нь үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ ХК-тай хамтран Монголд анх удаа нислэгийн миль хуримтлуулах урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болж, ХААН Банкны Гүйцэтгэх захирал Жон Белл, МИАТ ХК-ийн Гүйцэтгэх захирал Т.Тамир нар гэрээг үзэглэлээ.

Миль хуримтлуулах урамшуулалт хөтөлбөрийг ХААН Банкны Платинум кредит карттай хослуулан нэвтрүүлж байгаа юм. ХААН Банк, МИАТ ХК-ийн хамтарсан "Миль хуримтлуулах урамшуулалт хөтөлбөр" хэрэгжиж эхэлснээр ХААН Банкны Платинум кредит карт эзэмшигчид картынхаа хэрэглээнд харгалзах миль оноог хуримтлуулан тус оноогоор МИАТ-ын нислэгийн үнэгүй тийз авах, суудлын ангилал дээшлүүлэх, "Чингис хаан" олон улсын нисэх буудлын бизнес лоунжаар үйлчлүүлж болох юм.

Хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурах ёслолын үеэр ХААН Банкны Гүйцэтгэх захирал Жон Белл: "Олон улсад агаарын тээврийн компани болон банкны хамтарсан милийн урамшууллын хөтөлбөрууд олон байдаг. Энэхүү Олон улсын жишиг урамшууллын хөтөлбөрийг Монголд анх удаа ХААН Банк, МИАТ ХК-тай хамтран хэрэгжүүлэх болсондоо баяртай байна. ХААН Банкнаас зээлийн эрхтэй кредит картууддаа олон улсын жишигт нийцсэн урамшуулал давуу талыг санал болгох олон ажлуудыг хийсээр байгаа билээ. Үүний томоохон жишээ нь өнөөдрийн эхлүүлж буй Платинум кредит картаараа миль хуримтлуулах урамшуулалт хөтөлбөр юм" хэмээн онцоллоо.

МИАТ ХК-ийн Гүйцэтгэх захирал Т.Тамир: "Олон жил хүлээлттэй байсан миль хуримтлуулах хөтөлбөрийг бид ХААН Банктай хамтран анхлан эхлүүлж, ажил хэрэг болгож байна. Энэ удаад ХААН Банкны Платинум карттай харилцагчдад санал болгож буй бөгөөд цаашид бүх төрлийн карт эзэмшигчдээ урамшуулалт хөтөлбөрт хамрагдах боломж олгохоор ажиллаж байна" гэдгээ онцлон дурдлаа.

Ийнхүү олон улсын жишигт нийцсэн кредит картын хэрэглээндээ урамшууллын миль тооцуулах хөтөлбөр Монголын зах зээлд нэвтэрлээ. ХААН Банкнаас энэхүү хөтөлбөрийн нээлтийн бэлэг болгон 2017 оныг дуустал шинээр **Платинум кредит карт** эзэмшигч болсон бүх харилцагчиддаа **5000 миль** оноог шууд олгох юм. Дашрамд дурдахад 15,000 миль хуримтлуулахад Бээжин-Улаанбаатар чиглэлийн хоёр талын нислэгийн тийз авах боломжтой болдог байна. Харин өмнө нь Платинум карт эзэмшигч болсон харилцагчдын хувьд картаа идэвхтэй ашиглах тутам миль оноо илүү хуримтлуулна.

Харилцагчийн мэдээллийн төв **1800-1917** www.**khanbank**.com khanbank.com/**facebook** khanbank.com/**twitter**


| ХААН банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2423.00 | 2436.00 | ФУНТ | 2982.00 | 3074.00 |
| ЕВРО | 2552.00 | 2618.00 | РУБЛЬ | 42.00 | 44.00 |
| ИЕН | 21.85 | 22.16 | ЮАНЬ | 350.00 | 353.00 |

| Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2437.00 | 2451.00 | ФУНТ | 3150.00 | 3276.00 |
| ЕВРО | 2905.00 | 3010.00 | РУБЛЬ | 41.44 | 45.41 |
| ИЕН | 22.18 | 23.22 | ЮАНЬ | 375.00 | 380.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн Ховд аймагт ажиллаж байна

ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн баруун бүсийн таван аймгийн ХХААГ, сумдын Мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалт, мал амьтны гоц халдварт өвчний үеийн үзүүлэх сургалтын үйл ажиллагаанд оролцож байгаа бөгөөд үйл ажиллагааг нээж үг хэллээ. Тэрбээр "ХХААХҮЯ-наас санаачлан бүсийн зөвлөгөөнийг хийхээр болсон. Өнөөдөр бүсчилсэн сургалтын хаалт буюу баруун бүсийн сургалт болж байна. Зөвлөгөөний ач холбогдол их чухал. Салбарынхан маань харилцан танилцаж, туршлага солилцож, төв яамнаас нь явуулж бодлого, авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй танилцаж, хийж хэрэгжүүлж буй ажлаа хэрхэн хамтдаа хийх арга замаа тодорхойлж байна. ХХААХҮЯ-наас бодлого гаргадаг. Гаргасан бодлого шийдвэрийг хэрэгжүүлдэг газар нь хөдөө орон нутгийн ХХААГ. Тийм ч учраас энэхүү сургалт зөвлөгөөнийг жил бүр хийж байхаар төлөвлөсөн" гэв. Мөн Ховд аймгийн 17 сумын Мал эмнэлэг үржлийн тасагт мотоцикл гардуулан өглөө. Энэ нь анхан шатанд ажиллаж буй мэргэжилтнүүд Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын бодлого, бүс нутгийн хөгжлийн зорилт, үйл ажиллагааг орон нутагт амжилттай хэрэгжүүлэхэд, онцгой хувь нэмэр оруулж, ард иргэдэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт итгэлтэй байна гэж сумдын мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтнүүд ярьж байв. Түүнчлэн сургалт зөвлөгөөний нээлтийн үеэр аймгийн ХХААГ-т фургон автомашиныг гардуулан өгсөн юм.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ХЭЛМЭГДЭГСДИЙН АР ГЭРИЙНХНЭЭС УУЧЛАЛ ХҮСЛЭЭ

...Онцгой бүрэн эрхт комисс гэх хэлмэгдүүлэлтийг гардан хэрэгжүүлэгч бүтэц 25 мянга 824 хүнийг хилс хэрэгт унаган таслан шийтгэснээс 20 мянга 474-т нь буудан алах ял оноож байжээ. Нийт 17 мянга орчим лам хуврag хилс хэрэгт шийтгэгдсэний 14 мянга нь цаазаар авахуулсан байна...



**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Их хэлмэгдүүлэлтийн талаарх Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссоос гаргасан тоо баримтуудаас заримыг нь дурдахад л сэтгэл хирдхийлгэж байна. 1937-1939 он хүртэл хоёр жилийн хугацаанд Онцгой бүрэн эрхт комисс гэх хэлмэгдүүлэлтийг гардан хэрэгжүүлэгч бүтэц 25 мянга 824 хүнийг хилс хэрэгт унаган таслан шийтгэснээс 20 мянга 474-т нь буудан алах ял оноож байжээ. Нийт 17 мянга орчим лам хуврag хилс хэрэгт шийтгэгдсэний 14 мянга нь цаазаар авахуулсан байна. Энэ бол сонссон монгол хүн бүр сэтгэл шимшрэхгүй байхын аргагүй тоо! Энэ бол Монголын өв уламжлал, язгуур сэтгэлгээ, үндэстний ой санамж, эх оронч тэмүүллийг хэдий хэмжээгээр тастан хаясныг илтгэх тоо. Улс төрийн хэлмэгдүүлэлт бол аль ч цаг үед Төрөөс гаргаж, давтаж болохгүй балмад үйлдэл бөгөөд үндэстний тэргүүний оюун ухаан, дархлааг мөхөөх далд явуулгын илэрхийлэл юм. Монголын төр ахин хэзээ ч ард иргэдээ хэлмэгдүүлэхгүй байх, төрийн өндөр албан тушаалтнууд улс төрийн зорилгоор өрсөлдөгчдөө хэрэгт унагаадаг шат дамжлага, шударга бусын хонгилыг төрийн бүтцийг ашиглан бий болгодоггүй байх тийм бат бөх ардчилал, шударга ёс бүхий иргэний төрийг бид өдөр тутмын шаардлага, сонор сэрэмжээрээ л бий болгож, бэхжүүлэх учиртайг би энэ өдөр ахин дахин сануулмаар байна. Үүний тулд Монголын төр хэлмэгдэгсдээс, тэдний гэр бүл, үр хүүхэд, залгамж хойчоос оройтсон ч гэсэн бүрэн уучлал гуйх ёс зүйтэй байх ёстой. Би ард олныхоо итгэлээр Монголын төрийг тэргүүлж байгаагийн хувьд өнөөдөр Улс төрийн хэлмэгдэгсдээс, тэдний гэр бүл, төрөл төрөгсдөөс гүнээ уучлал гуйж байна. Хүлээж авна уу. Монголын төр дахин хэзээ ч ийм алдаа гаргах ёсгүй. Хойч үе маань үүнийг хэзээ ч бүү мартаг! Их хэлмэгдэлд өртөн амь нас, эрүүл мэндээрээ хохирч, ажил амьдралаа алдсан Та бүхний хохирлыг юугаар ч нөхөж чадахгүй. Энэ бол монгол үндэстэнд учирсан асар том гарз хохирол байсан. Сайн амгалан болтугай. Монгол оронд эрх чөлөө, хүний эрх үеийн үед дэлгэрэх болтугай" хэмээн хэллээ.

МИНФО.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

## Японы Ерөнхий сайдын тусгай элч Мото-о Хаяаши Монголд айлчиллаа

Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ойн хүрээнд манай улсад албан ёсны айлчлал хийсэн Япон Улсын Ерөнхий сайд Ш.Абэгийн тусгай элч, Японы Улсын Парламентын Төлөөлөгчдийн танхим дахь Япон-Монголын найрамдлын бүлгийн дарга Мото-о Хаяаши өнгөрсөн баасан гарагт Төрийн ордонд айлчлалынхаа талаар сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ. Тэрбээр "Энэ жил Япон Улс, Монгол Улс дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ой тохиож байна. Тэмдэглүүштэй энэ ойн жил Японы парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга Т.Оошима Төлөөлөгчдийн танхимын даргын хувиар анх удаагаа Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн. Харин энэ удаа Японы Парламентын Төлөөлөгчдийн танхим дахь Япон-Монголын найрамдлын бүлгийн зүгээс албан ёсны айлчлал хийж байна. Айлчлалыг маш үр дүнтэй, чухал ач холбогдолтой болгохын төлөө, түүнчлэн бусад олон чиглэлээр хоёр улсын харилцааг хөгжүүлэхийн төлөө Японы Парламентын Төлөөлөгчдийн танхим дахь Япон-Монголын найрамдлын бүлэг Улсын Их Хурал дахь Монгол-Японы найрамдлын бүлэгтэй нягт хамтран ажиллаж, хүчин зүтгэх бодолтой байна" хэмээв. Тэд айлчлалынхаа хүрээнд Ерөнхийлөгч Х.Баттулга болон бусад албаны хүмүүстэй албан ёсны уулзалт хийсэн юм. Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ойн хүрээнд болсон энэхүү албан ёсны айлчлал баямба гарагт өндөрлөсөн билээ.

## Хамбын овоонд хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэлээ

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг жил бүрийн есдүгээр сарын 10-ны өдөр орон даяар хүндэтгэн дурсдаг билээ. Монгол Улсад улс төрийн хилс хэргээр лам хуврag, эрдэмтэн сэхээтэн, ард иргэдээ хоморголон хэлмэгдүүлсний 80 жилийн ой энэ онд тохиож байна. Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс хамтарч лам хувраагуудыг олноор цаазлан хороосон газар болох Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр дэх Хамбын овоонд өнгөрсөн бямба гарагт хэлмэгдэгсдийг хүндэтгэн дурсгалыг хүндэтгэх үйл ажиллагааг зохион байгууллаа. Уг үйл ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Соёл, шашны бодлогын зөвлөх Ц.Хулан, Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн тэргүүн, хамба лам Д.Чойжамц тэргүүтэй албан хүмүүс болон жүжигчид, уран бүтээлчид, лам хуврag, сурагч хүүхдүүд, ард иргэдийн төлөөлөл оролцлоо. Энэхүү түүхэн газрын орчмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар дархалж, түүхэн хүндэтгэл, дурсгалын сүм барих талаар Засгийн газарт чиглэл өгсөн зарлигийн эхийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас бэлтгэж байгааг энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Соёл, шашны бодлогын зөвлөх Ц.Хулан хуран цугларсан олонд дуулгалаа. Тухайн орчимд нийтдээ 1886 метр буюу 16 га газарт хэлмэгдэгсдийн хороож булсан байдаг ажээ. Хүндэтгэлийн энэхүү үйл ажиллагааны үеэр сайн дураараа, өөрийн багш Г.Пүрэвбат ламтны даалгаснаар энэ газрыг ариун дагшин чигээр хадгалахын тулд Хамбын овоог сахин хамгаалж, үнэн түүхийг хойч үед үлдээх хүмүүнлэгийн үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж яваа "Соёмбо сүм" ТББ-ын тэргүүн, лам Б.Ариунбуянд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболдын гарын үсэг бүхий талархлыг Ерөнхийлөгчийн зөвлөх Ц.Хулан гардуулан өгөв. Мөн их хэлмэгдүүлэлийн гашуун сургамжаас өгүүлсэн Д.Энхболдбаатарын зохиол "Амьдрал чиний төлөө" жүжгийн хэсгээс Д.Нацагдоржийн нэрэмжит Улсын драмын эрдмийн театрын уран бүтээлчид тоглож үзүүлсэн юм.

## БЗД-ийн 24-р хорооны хүүхдүүд цэцэрлэгтэй боллоо



Улаанбаатар хотын хэмжээнд огт цэцэрлэггүй 25 хороо байгаагаас Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороо АНУ-ын буцалтгүй тусламжаар баригдсан 251 дүгээр цэцэрлэгээ өнгөрсөн баасан гарагт хүлээн авлаа. Тус цэцэрлэг ашиглалтад орсноор нийслэлийн хэмжээнд цэцэрлэггүй хорооны тоо нэгээр хасагдаж байгаа юм. Улмаар тус хорооны 80 хүүхэд шинэ цэцэрлэгтэй болж, цоожтой хаалганы цаана бус цэцэрлэгт хүмүүжих боломж бүрдсэн юм. Өнгөрсөн зургадугаар сард цэцэрлэгийн шав тавьж байсан бол шинэхэн барилгадаа 80 хүүхэд хүлээн авч 16 багш ажилчдыг ажлуулах боломж бүрджээ Цэцэрлэгийн нээлтэд БСШУС-ын сайд Г.Чулуунбаатар, АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Женифер Зимдал Галт, БСШУСЯ-ны Олон улсын төсөл, хөтөлбөр гадаад хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Ж.Бямбацогт, Үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Н.Отгонбаяр болон бусад албаны хүмүүс, 24 дүгээр хорооны иргэд эцэг, эчхүүдийн төлөөлөл оролцлоо.

## "Монгол хүний эрүүл мэнд – хүнсний аюулгүй байдал" сэдэвт салбар хуралдаан боллоо

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын санаачилгаар "Монгол Улсын хүнсний аюулгүй байдал" сэдвээр энэ сарын 12-нд үндэсний чуулган зохион байгуулах гэж байна. Чуулганыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, ХХААХҮЯ, Монголын хүнсчдийн холбоо, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хамтран зохион байгуулах юм. Монгол Улсын хүнсний салбарын өнөөгийн байдлыг тодорхойлох, хүн амын гол нэрийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах, хүнсний хангамжийг сайжруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулж, шийдвэрлүүлэхэд "Монгол Улсын хүнсний аюулгүй байдал" сэдвээр хийх үндэсний чуулганы зорилго оршиж байна. Үндэсний чуулганы өмнө салбар хуралдаанууд хийж байгаа бөгөөд бямба гарагт Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд "Монгол хүний эрүүл мэнд – хүнсний аюулгүй байдал" сэдэвт салбар хуралдаан болжээ. Энэ удаагийн салбар хуралдаанаар хүнсний аюулгүй байдлын чиглэлээр судалгаа шинжилгээний ажил явуулж буй эрдэмтэд, эмч, анагаах ухааны мэргэжилтнүүдийн санал бодлыг сонсож, хүнсний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл, хүнсний аюулгүй байдал монгол хүний эрүүл мэнд, генийн санд хэрхэн нөлөөлж буй талаар хэлэлцлээ. Уг салбар хуралдаанаар "Монгол хүний эрүүл мэнд – хүнсний аюулгүй байдал", "Анхан шатны эмнэлгийн байгууллагад хандаж буй өвчтөн, тусламж авч буй иргэдэд тохиолдож буй өвчлөлийн шалтгаанд хүнсний аюулгүй байдал нөлөөлж буй нөлөө", "Монгол улсын сахарын хэрэглээ, түүний эрүүл мэндийн нөлөөлөл" зэрэг сэдвээр илтгэл сонсч, оролцогчид хэлэлцүүлэг өрнүүлсэн байна.

## ҮЗЭЛ БОДОЛ

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

# МОРДОХЫН ХАЗГАЙ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**



60 тэрбумын хэрэг сөхөгдөж, М.Энхболд сонгуульд ялагдал хүлээсний дараа МАН-ын дараачийн дарга бөгөөд Ерөнхий сайд нь У.Хүрэлсүх юм байна гэж олон нийт харж байв. Намынх нь олон гишүүд ингэж хүссэн байх. Гэтэл М.Энхболд тийм амар тахимаа өгдөг хүн биш бололтой. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатад намын даргын суудал шилжих шинжтэй болоод ирэнгүүт У.Хүрэлсүх нь Ж.Эрдэнэбаттайгаа ноцолдож эхэлсэн. Эхний барьц нь "У.Хүрэлсүхийг намын дарга болгохгүйн тулд тагнаж чагнасан" гэх дуулиан. Мэдээж энэ хангалтгүй байсан учраас /хуулийн байгууллагаар нотлуулах боломжгүй/ ОУВС-тай байгуулсан гэрээ, хүүхдийн мөнгийг хууль зөрчиж олгосон, УИХ-аас зөвшөөрөл авалгүй хууль зөрчиж гэрээ байгуулсан 800 тэрбумын концессоор шалтаглан УИХ-ын гишүүдээр гарын үсэг зуруулж Засгийн газраа хоёр сар ноолов.

Уг нь ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдах асуудлыг Засгийн газар 65-ын бүлэг болон УИХ-аар хэлэлцүүлж, нөгөөдүүл нь хэлэлцэж хэлэлцэж, хэрэлдэж хэрэлдэж "хямралаас гарахын тулд явахаас аргагүй зам байна аа" гээд шийдсэн. Үүнд нь нийгмийн зүгээс асар их шүүмжлэл дагуулж, сонгуульд ялагдах гол шалтгаан болсон нөгөө л хүүхдийн мөнгийг хассан, тэтгэврийн насыг нэмсэн, татвар нэмэгдүүлсэн асуудлууд нь бүгд багтсан шүү дээ. Хоёрдугаарт, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө Засгийн газар өмнөх шийдвэрээсээ буцаж, хүүхдийн мөнгийг ялгаварлалгүйгээр тэгш олгох болсон нь МАН-ынхны сонгогчдын саналыг татах гэхдээ аргагүйдэж гаргасан шийдвэр. Хэдийгээр МАН нэмэх оноо авчраагүй иргэдийн эрх ашигт нийцсэн шийдвэр. Тиймээс сонгуулийн дараа "Хүүхдийн мөнгийг үргэлжлүүлэхийн тулд яаралтай хууль батлах хэрэгтэй. Тэгэхгүй бол Засгийн газрын шийдвэр хууль бус болж харагдаад байна шүү" гэдгийг сануулж хэлсээр байхад УИХ өөрөө хүлээж аваагүй шүү гэдгийг Л.Болд гишүүн ээлжит бус чуулганы хуралдаан дээр сануулсан.

Тэгэхээр Засгийн газар огцорсон шалтгаануудаас хамгийн үндэслэл бүхий нь 800 тэрбумын концесс л болж байна. Хорин сайхан шарыг минь хоёрхон хулгана идчихлээ гэж үү гэдэг л болсон хэрэг л дээ. Өөрөөр хэлбэл, зах зээл дээр алт зэс, нүүрсний үнэ өсөөд, эдийн засаг сэргэх циклдээ ороод ирэнгүүт энэ өсөлтийг хэн хуваарилах вэ гэдэг зодоон л МАН дотор болж байна. Энэ бол таамаглал биш, улстөрчдийн үг, үйлдэлд эдийн засагчид, судлаачдын хийж байгаа дүн шинжилгээ. Харин одоо хуваарилалтыг хэн хийх вэ, шинэ Засгийн газрыг хэн толгойлох бол гэдэг л хэн хүний анхаарлыг татаж эхэлсэн нь мэдээж.

УИХ-ын гишүүн асан Х.Тэмүүжин энэ тухай "Засаг огцорсноор баатруудын үе дууссан. Одоо хуйвалдагчид засгаа томилно" гэв. Нэг ёсондоо У.Хүрэлсүхийн ярьж байсан "намын шинэчлэл" мэт нь хуйвалдааны зэвсэг төдий болоод, нэг удаагийн хэрэглээ, амны цаас болоод өнгөрөх магадлалтай гэсэн үг. Нам дотроо ярих ёстой асуудлыг засаг руу чирч оруулж ирээд УИХ-аар шийдүүлэх гэж оролдсоны гай. Одоо Засгийн газар хэр удаан хугацаанд үүрэг гүйцэтгэгчтэй явахыг таах боломжгүй болов. Шинэ Засгийн газрын тэргүүнийг УИХ-аар оруулж батлуулах хуулийн хугацаа 30 хоног. 45 хоногийн дотор Засгийн газар бүрдэхгүй бол УИХ өөрөө тарах хуулийн заалттай. Энэ хугацаанд МАН бага хурлаа хуралдуулаад Ерөнхий сайдад нэр дэвшүүллээ гэхэд /Намын дүрэмд нь "Ерөнхийлөгчид нэр дэвшигч болон Ерөнхий сайдыг Бага хурлаас нэр дэвшүүлэх" заалттай/ шинээр томилогдсон Ерөнхий сайд намын даргаа авах уу, үгүй юу гэдэг асуудал давхар сөхөгдөж таарна. УИХ-ын дарга З.Энхболдыг АН-ын даргаар томилогдох хүртэл "Ялсан намын дарга нь Ерөнхий сайд байна" гэсэн зарчим үйлчилж байв. Намын дүрэмд нь ч бас тийм заалт бий. З.Энхболдын үед тогтоосон энэ буруу жишгийг М.Энхболд үргэлжлүүлсний гайгаар Ж.Эрдэнэбатын Засгийн газар ийнхүү огцров. Өнөөдрөөс шинээр томилогдох Ерөнхий сайдын асуудалтай цуг намын даргын асуудал ч бас яригдаж таарна. Намын дарга нь Ерөнхий сайд байх уу, үгүй юу. Намын дарга нь Ерөнхий сайд байна аа гэвэл Бага хурлаас нэр дэвшигдсэн шинэ даргаа намын их хурал нь батламжлах уу. Батламжилдаг байлаа гэхэд цаг хугацааны хувьд боломжтой юу.

...Уг нь У.Хүрэлсүхийн сонгуулийн дараа ярьж эхэлсэн "намын шинэчлэл" зөвийн зөв байлаа. 60 тэрбумын хэргээс болж шаварт унасан МАН-ын нэр хүндийг эргүүлж босгох ганц зүйл нь нам доторхи шинэчлэл байсан уу гэвэл байсан. Гэвч эрх барьж байгаа нам дотор шинэчлэл явагдахаасаа илүү эрх мэдлийн төлөөх тэмцэлдээ идүүлээд дуусдагийг өмнө нь АН-ынхан харуулсан...

Учир нь МАН-ын дүрэмд зааснаар намын Бага хурлаас намын Их хурал зарлахдаа 45-аас доошгүй хоногийн өмнө зарлах ёстой. Хэрвээ намын дарга нь Ерөнхий сайд байна гэвэл Үндсэн хуульд заасан 45 хоногийн хугацаа хүрэлцэхгүй болоод байгаа юм. Тиймээс энэ УИХ өөрөө тарчихгүйн тулд хуулийн хугацаанд нь Засгийн газраа байгуулья гэвэл эхлээд Ерөнхий сайдаа томилох хэрэгтэй болж байна. Харин МАН-ын Бага хурлаас нэр дэвшигдэж гарч ирсэн Ерөнхий сайд нь хэдий хугацаанд засаглах вэ. "Энэ хүн манай намын дараачийн дарга байгаа юмаа" гээд Бага хурлаасаа Ерөнхий сайдаа гаргаад УИХ-аар томилуултал 45 хоногийн дараа хуралдах Их хурал намын даргаа батламжлахгүй бол яах юм. Хэрэв тэгвэл шинээр томилогдсон намын дарга нь Ерөнхий сайдаа бүрэн эрхийнх нь хугацааг дуустал ажиллуулах болов уу. Ийм л эрсдэлтэй нөхцөл байдал дунд шинэ Засгийн газрыг эмхлэн байгуулах үүрэг МАН-ын бүлэгт оногдоод байна. Тэр тусмаа 65 гишүүнтэй бүлгийн 65 тусдаа эрх ашиг, амбиц, шуналыг дараа дараачийн Засгийн газрууд нь тэсвэрлэж гарах нь юу л бол.

Уг нь У.Хүрэлсүхийн сонгуулийн дараа ярьж эхэлсэн "намын шинэчлэл" зөвийн зөв байлаа. 60 тэрбумын хэргээс болж шаварт унасан МАН-ын нэр хүндийг эргүүлж босгох ганц зүйл нь нам доторхи шинэчлэл байсан уу гэвэл байсан. Гэвч эрх барьж байгаа нам дотор шинэчлэл явагдахаасаа илүү эрх мэдлийн төлөөх тэмцэлдээ идүүлээд дуусдагийг өмнө нь АН-ынхан харуулсан. Одоо МАН дахин нотолж байна.

Зүй нь, У.Хүрэлсүх Засгийн газартай ноцолдож байхаар Бага хурлаа хуралдуулаад намын даргаа авчихсан бол дараа нь С.Баяр шиг "Намын дарга нь Ерөнхий сайд байна аа. Хариуцлагыг үүрвэл үүрсэн шиг үүрье" гээд засгаа авчих боломжтой байх байлаа. Тэгсэн бол жинхэнээсээ салбараа мэддэггүй "мөнгөний" сайд нартай хариуцлага яриад сууж байх байлаа. Олон нийт ч гэсэн тийм хүлээлттэй байлаа. Харин одоо огт өөр зүгийн салхи салхилаад эхэллээ. У.Хүрэлсүх ч гэсэн өөрөө "хариуцлагагүй алдсан" Засгийн газартай хамт огцорчихоод эргэж хараад "Ерөнхий сайд болъё" гэх боломжгүй. Мордохын хазгай гэдэг л энэ байх.




Дугаарын 60 мөр

## Нэртэйгээр нь Монгол нэрээ, "Орк"-оор сольчих

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Дээл өмсөөд гудамжаар алхан "Аан нэг муу орк явна". Зогсоолд машин таглаж зогсвол "Аан муу орк". Жорлонгийн хананд байршуулсан заавры хүртэл "Орк заавар" гэх. Мөрөөрөө бүжиглэх нэгний зургийг дарж, "Орк дээрээ тавьсан байна" хэмээн жиргэх бөгөөд бүр сүүлдээ "Орк.мн" гэх вэб сайт хүртэл нээгдэж, нөгөө л орктой холбоотой мэдээллийг нийтэлдэг болжээ.

Нэг мэдэхэд л миний Монгол хэлний сан хөмрөг шинэ үг ойлголтоор баяжсан байх юм. Орк нь "хөдөөний, бүдүүлэг харанхуй" гэх утгатай үг гэнэ. Урьд соёлгүй, боловсролгүй нэгнээ монголчууд "Зайлуул даа, малын захаас холдож үзээгүй юм" гэж өмгөөлдөг байсан юм гэнэ билээ. Харин одоо орк гэж дуудуулаагүй монгол хүн ч гэж үгүй болж. Өөрийгөө хотын соёл мэддэг, соёлтой гэж дүрдээ итгэсэн хэсэг нь бусдыгаа "орк" хэмээн хочилж, түүнээсээ баясал мэдэрдэг бололтой. Гэтэл хэн нэгний тоглоом тохуу болгож ашигласан үг нь савнаасаа хэдийнэ хальж, шоглоом болж гүйцлээ.

Хэдхэн хоногийн өмнө Орхон аймагт "ОРО" гэх машины серийн дугаарын хязгаар дуусч, "ОРК" гэх шинэ серийн дугаар гаргажээ. Гэвч, нутгийн жолооч нар тус улсын дугаарыг голж, зарим нь Авто тээврийн бүртгэлийн байгууллагадаа гомдол хүртэл гаргасан байх юм.

Гэтэл "Орк" нь зохиол, уран бүтээлд гардаг зохиомол амьтны нэр аж. Энэ амьтан эртний домогт нэр нь дурьдагдсан байх авч, гол хэлбэр, утгаа олсон нь орчин үеийн фантаз уран зохиолын эцэг гэгддэг Английн зохиолч, яруу найрагч Жон Толкины уран бүтээлүүд юм байна. Түүний "Бөгжний эзэн", "Хоббит" зэрэг бүтээлд харгис, хэрцгий, түрэмгий, муу ёрын, чөтгөр шулмын амьтдыг орк гэж нэрлэдэг. Улмаар яг энэ дүрслэл, утга агуулгаар "Dungeons & Dragons", "Warhammer", " Warcraft" зэрэг тоглоомуудад дүрслэгдсэн байдаг юм. Кино, тоглоомд дүрслэгдсэн ногоон өнгөтэй, хүн дүрст адгуусан амьтдыг харин монголчууд "хөдөөний, бүдүүлэг харанхуй" гэсэн утгатай хэмээж, Монгол хэлний сан хөмрөгөө нэгээр нэмж байх жишээтэй. Бас болоогүй, нэг нэгнээ орк хэмээн дуудаж, үзлийн муухай амьтан мэтээр доромжлох.

Яах вэ, дээр дурьдсан орк маягийн авир гаргаж замын хөдөлгөөн, нийгмийн харилцаанд оролцох нэгэн байхыг үгүйсгэхгүй. Нэг хүний эрх ашиг, нийтийн эрх ашгаар хэмжигддэг болохоор шаардлага тавих нь байх л хэрэг. Гэхдээ үгийнх нь утга агуулгыг хөөргөж, нийслэлд төрсөн, хөдөө төрсөн гэдгээр нь ялгаж, өөрт нь таалагдаагүй үйлдэл хийснийх нь төлөө хараалын үг мэт болсон "орк"-оо уншина гэвэл эндүүрэл. Өөрийнхөө харах өнцгөөр бусдын оршихуйг хязгаарлаж, өөрөөс нь бусад бүхнийг "Орк" гэж нэрлэн нэг нэгнээ хэмлэх монголчууд ерөөсөө "Монгол" нэрээ "орк"-оор сольчихвол яасан юм. Тоглоом шоглоом тань савнаасаа хальж, Чингисийн Монгол, "Оркийн орон" болох нь, та минь ээ.

## ДЭЛХИЙ





# "ИРМА" ХАР САЛХИ ФЛОРИДАГ ДАЙРЛАА

Б.ДАВАА

Атлантын далайд урьд өмнө нь үзэгдэж байгаагүй Ирма хар салхи үүсч, замд таарсан улс, үндэстэн бүрт томоохон хэмжээний хохирол учруулан урагшилсаар байна.

Хар салхи өнгөрсөн долоо хоногт Карибын тэнгисийн бяцхан арал Барбудаг дайрч, оршин суугчдын байр сууцны 90 хувийг сүйрүүлэн, үндсэндээ балгас болгосон юм. Тэгвэл өнгөрөгч бямба гарагт Кубын хойд эргийг дайран өнгөрчээ. Тухайн үед гамшгийн бүсээс нүүгээгүй эргийн оршин суугчид "Салхины чимээ аймшигтай чанга хүнгэнэж, байшингийн дээвэр дээр мод, цахилгааны шон хугаран унаж, басхүү дээврийн мод төмөр хийсч байсан" хэмээн ярьсан байна.

КубаИрмахарсалхитусулсын хойд хэсгийг дайрч өнгөрнө гэсэн цаг агаарын урьдчилсан мэдээллийн дагуу гамшгийн бүсээс нэг сая гаруй иргэнийг нүүлгэн шилжүүлсэн байна. Одоогоор хүний амь эрсэдсэн гэсэн мэдээлэл байхгүй. Гэхдээ Кубын эрх баригчид дэд бүтцэд асар их хэмжээний хохирол учирсан гэдгийг тодотгож байгаа юм. Харин Карибын тэнгисийн арлуудыг хар салхи дайрахдаа хамгийн сүүлд авсан мэдээллээр 1.2 тэрбум еврогийн эд материалын хохирол учруулж, 25 хүний амь авч оджээ.

Асар их хөнөөлт хар салхи АНУ-ын Флорида муж руу аажим аажмаар ойртсоор манай цагаар өчигдөр 21.00 цагийн орчимд хүрчээ.

Хохирлын хэмжээ тодорхойгүй байгаа ч, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тус улсын иргэд хэдэн өдрийн өмнөөс авч хэрэгжүүлсэн юм. АНУ-ын Флорида муж 20 сая хүн амтай. Тэгвэл үүний гуравны нэг буюу 6.3 сая иргэнийг гамшгийн бүсээс аюулгүй бүс рүү нүүлгэн шилжүүлэх ажиллагаа сүүлийн өдрүүдэд үргэлжилсэн байна. Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээллээр Ирма хар салхи чиглэлээ өөрчилсөн тул цаашдаа зөвхөн тус мужид бус, Мексикийн баруун буланд хүрч ч болзошгүй байгаа аж.

Гэхдээ албаныхан Флорида мужийн баруун, зүүн булан, Миамигийн өмнөд хэсгээс Куба хүртэлх нутагт ихээхэн хэмжээний хохирол дагуулах урьдчилсан төлөвтэй байна. Тиймээс иргэдийг мужийн хойд хэсэг, хил залгаа орших Жоржиа муж руу нүүлгэн шилжүүлсэн байна.

Түүнчлэн, Флоридагийн өмнөд хэсэгт байрлах "Turkey Point" цөмийн цахилгаан станцын аюулгүй байдлыг хангахын тулд хоёр генераторынх нь нэгнийх нь ажиллагааг бүрэн зогсоожээ. Мөн тус мужид хүн амаараа гуравдугаарт ордог Тампа хотын цахилгаан түгээх компанийн хэрэглэгчдийн 70 хувь нь эрчим хүч авч чадахгүйд хүрч болзошгүй байна.

Өнгөрсөн сард АНУ-ын өмнөд хэсгийг "Харви" хар салхи дайран өнгөрсний улмаас Техас зэрэг мужуудад их хэмжээний хохирол учирсан юм. АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп Ирма хар салхи Флорида муж руу дөхөж буй мэдээлэл гарсан даруйд Засгийн газраа хуралдуулж, гамшгийн үед авах арга хэмжээ хийгээд урьдчилсан бэлтгэл ажлыг бүрэн дүүрэн хангаж ажиллах чиглэл өгчээ.

Хурлын эхэнд Трамп "Эд хөрөнгийг эргүүлэн олоход амархан боловч, амийг насыг дахиж олж чадахгүй. Аюулгүй байдал нэгдүгээрт. Ирма хар салхи ихээхэн хор хөнөөлтэй ч, бид урьдчилан сэргийлэх бэлтгэлээ хангаж чадна" гэдгийг онцолжээ.

Цагаан ордноос мэдээлснээр, Ерөнхийлөгч Д.Трамп хуралдааны үеэр Ирма хар салхи нутаг дэвсгэрийг нь дайран өнгөрөх орон нутгийн Засаг захиргаа, өөрөө удирдах байгууллагыг дэмжиж ажиллахын зэрэгцээ өнгөрсөн сарын сүүлчээр "Харви" хар салхины улмаас сүйдсэн нутгийн дэд бүтцийг сэргээн засварлах ажлаа үргэлжлүүлэхийг даалгасан байна. Нийгмийн сүлжээний идэвхтэй хэрэглэгч гэгддэг Трамп твиттер хуудастаа ч тасралтгүй жиргэсээр байгаа юм. Бямба гарагт гэхэд "Энэ бол маш их хор хөнөөл учруулах хүчтэй хар салхи. Тиймээс хар салхи дайран өнгөрөх бүс нутагт оршин сууж буй иргэд удирдлагуудынхаа зааврыг дагаж, бүгд аюулгүй бүс рүү нүүх хэрэгтэй" хэмээн бичиж, нийт иргэддээ анхааруулсан байна. Хэдий аюулгүй байдлаа хангаж ажилласан ч, нүүгээгүй үлдсэн хүмүүс ч байсан гэх мэдээлэл байгаа юм.

## Мексикт болсон газар хөдлөлтөөр 65 хүн нас баржээ

Мексикийн өмнөд хэсэгт баасан гарагт 8.2 магнитудын хүчтэй газар хөдөлсний улмаас нас барагсдын тоо аль хэдийнэ 65 болсон талаар орон нутгийн мэдээллийн агентлагууд дамжуулжээ. Гамшгийн бүсэд одоогоор байшингийн нурангид дарагдсан иргэдийн цогцсыг хайх ажиллагаа үргэлжилж байна. Мексикийн Оахака, Чиапас мужид байгалийн гамшигт үзэгдлийн улмаас амиа алдагсдын тоо нэмэгдэж байгаа аж. Харин хамгийн их хохирол амссан Хучитанд бямба гарагт хоол хүнсний тусламж хэрэгтэй иргэд дэлгүүр, хоолны газруудын гадна дугаарлаж, гэр бүлийн хэн нэгэн нь золгүй байдлаар амиа алдсан ард иргэд цэцэг гартаа барьж, оршуулгын ёслол үйлджээ. Мексикийн Ерөнхийлөгч Энрикью Пена Ньето "Манай улсад болсон газар хөдлөлт сүүлийн 100 жилд тохиогоогүй хэмжээний хүчтэй байлаа" хэмээгээд, нийслэл Мехико хотод 10 мянга гаруй хүн нас барсан 1985 оны газар хөдлөлтөөс ч илүү хүчтэй байсан гэдгийг онцолжээ.

Тодруулбал, энэ удаагийн газар хөдлөлтийн хүч 8.2 магнитуд байсан бол 1985 оны газар хөдөлт 8.1 магнитуд байжээ.

## Хойд Солонгос цөмийн инженерүүддээ талархал илэрхийлэв

Хойд Солонгосын төрийн өмчит KCNA агентлаг өчигдөр Ким Жон Ун нийслэл Пхеньян хотноо устөрөгчийн бөмбөгийн туршилтад ажилласан цөмийн инженер, судлаачиддаа талархал илэрхийлэх хүндэтгэлийн цайллагыг зохион байгуулсан тухай мэдээллээ. Тус цайллагын үеэр тус улсын удирдагч Ким "Устөрөгчийн бөмбөгийн туршилт амжилттай болсон" гэдгийг онцолсон тухай мөн дамжуулсан юм.

Тэрбээр "Хойд Солонгосын тухайд зургаа дахь удаагийн цөмийн зэвсгийн туршилт түүхэн үйл явдал" гээд цөмийн зэвсэгтэй улс гэдгээ бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрүүлэх зорилгоо биелүүлэхийн тулд илүү их хүчин чармайлт гаргахыг уриалжээ. Хойд Солонгос улс тусгаар тогтнолоо зарласан түүхт 69 жилийн ой энэ сарын 9-нд тохиосон юм. Тиймээс эл өдрүүдэд урлагийн тоглолт, цайллага гэх мэт төрөл бүрийн олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулагдаж байгаа аж. Цайллагаас гадна цөмийн зэвсгийн хөгжүүлэлтэд ажиллаж буй судлаачдад зориулсан урлагийн тоглолт ч мөн болж, тус улсын тэргүүн хатагтай Ри Сол Жу оролцжээ. Тэгвэл Хойд Солонгосыг ийн баяраа тэмдэглэж байхад НҮБ-ын төвшинд тус улсын эсрэг дахин шинэ хориг арга авах тухай яриа, хэлэлцээр эхэлжээ. АНУ-ын тал Пхеньяны эсрэг газрын тосны хориг тавих тогтоолын төслийг боловсруулсан бөгөөд өнөөдөр Аюулгүйн зөвлөлийн хурлаар хэлэлцэхээр болсон байна. Тус тогтоолд Хойд Солонгосын нэхмэл бүтээгдэхүүний экспортыг хязгаарлаад зогсохгүй, тус улсын ажиллах хүчийг гадаад улсад хөдөлмөр эрхлэхийг хориглох тухай тусгажээ. НҮБ дахь АНУ-ын суурин төлөөлөгч Никки Хейли "Вашингтон пост" сонинд өгсөн ярилцлагадаа "Аюулгүйн зөвлөлийн 15 гишүүн орны дэмжлэгийг авсан тохиолдолд тус тогтоол хэрэгжих боломжтой" гэж ярьжээ. Гэхдээ БНХАУ болон ОХУ эсрэг байр суурьтай байгаа аж. ОХУ-ын Төрийн тэргүүн В.Путины тухайд "Хориг арга хэмжээгээ чангатгах зарчмаар Хойд Солонгосын цөмийн хөтөлбөрийн асуудлыг шийдвэрлэх боломжгүй. Харин яриа хэлэлцээр хийх хэрэгтэй" гэдгийг онцолж байна. Энэ талаар НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш мөн байр сууриа илэрхийлжээ. Тэрбээр өчигдөр Францын "Le Journal du Dimanche" сонинд "Пхеньяны цөмийн болон пуужингийн хөгжүүлэлт нь сүүлийн жилүүдэд дэлхийн хамгийн ноцтой хямралыг үүсгэж буй бөгөөд асуудал хурцадсан" гэдгийг тодотгожээ. Түүнчлэн, тэрбээр Ким Жон Унд цөмийн болон тив алгасагч пуужингийн хөгжүүлэлтээ зогсоож, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн шийдвэрийг дагах сонголт байгаа гэдгийг онцолсон байна. Мөн "НҮБ-ын Аюулгүйн зөвлөл асуудлыг дипломат арга замаар шийдвэрлэх эрх бүхий цор ганц байгууллага. Тиймээс эв нэгдлийг хангах ёстой" гэж ярьжээ.



## Хиллари Клинтон шинэ ном бичжээ

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшиж өрсөлдөөд өвдөг шороодсон Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон ном бичжээ. Тэрбээр энэхүү номдоо өнгөрсөн жилийн сонгуулийн үйл явц хийгээд ялагдлын шалтгааныхаа талаар бичсэн аж.

Номдоо Хиллари өнөөгийн Ерөнхийлөгч Доналд Трампад ялагдсан нь өөрийнх нь үүрэх ёстой үүрэг хариуцлага гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Гэхдээ тухайн үеийн Ерөнхийлөгч Барак Обама, намын сунгаанд өрсөлдсөн сенатч Берни Сандерс, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин болон бусад маш олон хүмүүс ялагдалынх нь шалтгаан болсон гэж бичжээ. Хиллари Клинтоны номын нэр "What Happened" бөгөөд "Энэ миний тэмцэл, миний гаргасан шийдвэр байсан" гэх үгийг өмнөтгөл хэсэгтээ тодотгож өгсөн байна. Ном тун удахгүй худалдаанд гарах гэнэ.

Харин Хилларигийн тухайд нийслэл Вашингтоноос эхлээд 15 хотыг энэ сарын 18-аас эхлэн тойрч, номынхоо нээлтийг хийх аж.


**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗЭД ЕРӨНХИЙ ПРОДЮСЕР, МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР ШАЛГАРУУЛЖ АВНА**

Нэг. "MNB СПОРТ" СУВГИЙН ЕРӨНХИЙ ПРОДЮСЕР

**Тавигдах шаардлага:**
- Сэтгүүлч эсвэл найруулагчийн мэргэжилтэй,
- Хэвлэл мэдээллийн салбарт 3-аас дээш жил ажилласан туршлагатай
- Англи хэлний ярианы болон бичгийн дундаас дээш түвшний мэдлэгтэй
- Хамт олныг удирдан зохион байгуулах, багаар ажиллах болон харилцааны өндөр соёлтой, стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөлт хийх, хэрэгжүүлэх, хариуцлага хүлээх чадвартай байх
- Спортын мэдлэгтэй, телевизэд ажиллаж байсан бол давуу тал болно

Хоёр. МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР

**Тавигдах шаардлага:**
- Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй, маркетинг, менежментийн чиглэлийн мэргэжилтэй,
- Мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай, судалгааны ажил хийж байсан, телевизэд ажиллаж байсан бол давуу тал болно
- Англи хэлний ярианы болон бичгийн дундаас дээш түвшний мэдлэгтэй
- Маркетингийн судалгаа, шинжилгээ хийх, төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үр дүнд анализ хийх чадвартай
- Харилцааны өндөр соёлтой

**Бүрдүүлэх материал:**
- Дэлгэрэнгүй анкет /www.mnb.mn сайтын "Бусад" гэсэн хэсэгт буй МҮОНРТ-ийн ажилтны анкетыг бөглөх/
- Их, дээд сургууль төгссөн диплом болон бусад материалыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Урьд ажиллаж байсан байгууллага, хүмүүсийн тодорхойлолт
- 1 хувь цээж зураг
- Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн битүүмжилсэн дугтуйд хийж 2017 оны есдүгээр сарын 15-ны өдрийн 17:00 цаг хүртэл хугацаанд доорхи хаягаар ирүүлнэ үү.

**Хаяг: Баянгол дүүрэг, Хувьсгалчдын зам-3**
**Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз**
**Хүний нөөцийн алба**
**Утас: 11 325802**
**Цахим хуудас: www.mnb.mn**

# ОНЦЛОХ ХУУДАС

**Сенсаацийн эргэн тойронд**

# ОФФШОР ДАНСТНУУДАД ӨГСӨН 49 ХОНОГИЙН ХУГАЦАА ДУУСЛАА

Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн нэгдлээс 2016 онд 215 мянган оффшор компани, улс орны удирдагч, нөлөө бүхий улстөрчид татвараас зайлсхийж, мөнгө угаасан баримт нотолгоо бүхий 11.5 сая нууц баримтыг зарласан билээ. "Panama papers"-ын зүгээс зарласан оффшортой холбоотой энэхүү мэдээлэлд Монголын 49 хүний нэр дурьдагдсан билээ. Үүнээс гадна гадаадад байрлах дансандаа сая ам.доллар мартсан нэг л хүний тухай бид мэдэж байсан. Тэгвэл энэхүү мэдээлэл цацагдсанаас хойш монголчууд оффшор дансанд асар мөнгө хадгалж байгаа тухай мэдээлэл хөвөрч эхэлсэн билээ. Тухайлбал, АТОЗ-ийнхөн гэхэд нэр бүхий улстөрчид оффшор дансанд 17 тэрбум ам.доллар нуусан гэж мэдээлж байсан билээ. Харин Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ажлаа авсныхаа дараахан оффшор дасньтай холбоотой асуудлаар төрийн албан хаагчид, тэдний хамаарал бүхий этгүүдүүдэд хандаж уриалга гаргаж, 49 хоногийн хугацаа өгсөн билээ. Тэгвэл тэрхүү хугацаа дуусч байна. Тиймээс "Монголын мэдээ" сонин энэ удаагийн "Онцлох хуудас"-аараа оффшортой холбоотой асуудлыг хөндөж байна.

**С.Батчулуун: 49 дэх хоногт Ерөнхийлөгчид тэрбум ам.долларын хөдөлшгүй баримтыг хүлээлгэж өгнө**

**2017.09.05**

"Ард түмний онц түр зөвлөл"-ийн ерөнхий зохицуулагч С.Батчулуун энэ сарын 5-нд мэдээлэл хийсэн билээ. Тэрбээр "УИХ-ын намрын чуулганы нээлтэд оффшор бүсэд хамааралтай тэнд данстай Олон улсын сэтгүүлчдийн нэгдсэн консерциумаас дэлхий даяар тодорхой зарлагдсан Панамын бичиг баримтын дагуу нэр дурдагдсан Сү.Батболд, Б.Дэлгэрсайхан, Б.Энх-Амгалан, Л.Элдэв-Очир, Д.Цогтбаатар, С.Баяр болон С.Баярцогт нарыг нийгмээс тусгаарлаж, саатуулж байцаах. Мөн Ц.Сандуй болон түүний дүү н.Сэргэлэнг нийгмээс тусгаарлан саатуулж шалгах хэрэгтэй гэсэн шаардлагыг АТОЗ хүргүүлнэ. Тэнд дурдагдсан офшор данстнууд, Их Хурлын гишүүдийн эрхийг түтгэлзүүлэн хэрэг үүсгэн байцаах шаардлагыг хүргүүлж байгаа. Ерөнхийлөгчийн зарласан 49 хоног дуусахад ес хоног үлдлээ. Бид анхааралтай ажигласаар байна. Бид 49 дэх хоногт Ерөнхийлөгчид наад зах нь нэг тэрбум орчим ам.долларт хамаарагдах хөдөлшгүй, няцаагдашгүй баримтыг эх хувиар нь хүлээлгэж өгнө. Тэрхүү баримтыг хүлээлгэж өгсний дараа Ерөнхийлөгч тодорхой хэмжээнд мэдээлэл өгөх байх" хэмээсэн юм.

**Оффшорын асуудлыг мөрийн хөтөлбөртөө тусгахыг нэр дэвшигчдэд уриалав**

**2017.05.15**

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших хүмүүс тодорхой болохтой зэрэгцээд л оффшор данстай холбоотой асуудлыг АТОЗ-өөс хөндөж тавьсан. Тэд Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдэд хандаж мөрийн хөтөлбөртөө оффшорын асуудлыг тусгахыг уриалсан билээ. Тодруулбал, Оффшор бүст нэр бүхий улс төрчид 17 тэрбум төгрөг байрлуулсан тухай мэдээлэл гарсан. Уг хөрөнгийг эх оронд нь буцаан авч ирэх, нуусан этгээдүүдэд хариуцлага тооцох асуудлаар АТОЗ хоёр удаа жагсаал зохион байгуулаад байгаа юм. Гэвч Ерөнхийлөгч, Засгийн газар, УИХ болон хууль хяналтын байгууллагууд тодорхой арга хэмжээ хэрэгжүүлэхгүй байгааг тус зөвлөлийн ерөнхий зохицуулагч С.Батчулуун хэллээ. Мөн тэрбээр "Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж буй эрхмүүд оффшорын асуудлыг шийдвэрлэх заалтыг мөрийн хөтөлбөртөө оруулах хэрэгтэй. Тэгж чадсан хүнийг АТОЗ болон Монголын ард түмэн дэмжих болно. Харин оффшорын эсрэг асуудлыг мөрийн хөтөлбөртөө оруулаагүй улс төрийн хүчин, нэр дэвшигчийг сонгохгүй. Нэр дэвшигчид иргэдэд олон сайхан амлалт өгнө. Гэвч түүнийг нь хэрэгжүүлэх төсөв хөрөнгө Монгол Улсад байхгүй. Тиймээс оффшор бүст байгаа хөрөнгийг татаж, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж, амлалтаа биелүүлэх ёстой. Тэгэхгүй бол дахиад л гадаадаас зээл авах асуудал яригдах болно" хэмээн хэлж байсан юм.



**"Монголын 40 гаруй хүний оффшор данстай холбоотой асуудлыг шийдэх ёстой"**

**2017.08.02**

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга наймдугаар сарын эхээр АТГ-ын дарга тэргүүн комиссар Х.Энхжаргал, Монгол Улсын Ерөнхий прокурор, Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх М.Энх-Амгалан нарыг хүлээж авч, уулзсан билээ. Энэ үеэрээ оффшортой холбоотой асуудлыг ахин хөндсөн юм. Тэрбээр "Иргэдийн зүгээс энэ хоёр асуудал дээр ихэд идэвхжиж байна. Нийгэмд байгаа бухимдал шударга бус зүйлтэй Монгол Улсын шинэ Ерөнхийлөгч яаж тэмцэх вэ гэдгийг анхаарч байгаа тул хамтын ажиллагаагаа ил болгомоор байна. Ерөөсөө ч Ерөнхийлөгчийн сонгуулийг ийм хүлээлтээр хийсэн. Үйл ажиллагааг идэвхжүүлэхийн тулд гадаадын холбогдох байгуулллагатай харилцан туслалцаж, хамтран ажиллах хэрэгтэй. Иргэдийн чих тавин хүлээж буй эдгээр асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэх ажлыг гардан хийх ёстой хүмүүс нь та нар. Энэ ажилд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс тусалж дэмжихэд бэлэн байна. Монголбанкны ерөнхийлөгчтэй өчигдөр уулзах үеэрээ алттай холбоотой асуудлаар бас ярилцсан. Алтны компаниуд Монгол банкинд алтыг иргэнээр тушаадаг. Валютын нөөцийг алттай адилаар үздэг тул тушааж буй алтны хэмжээг бас харах нь чухал. Алт болон газрын баялгаас үүссэн хөрөнгө оффшор данс руу орох хандлага байдаг тул үүнд мөн анхаарах ёстой. Пакистаны Ерөнхий сайдын хүүхдүүд гадаадад оффшор данстай байсан нь илэрч, зохих байгууллагууд шалгасны үр дүнд Ерөнхий сайд огцорсон байна. Энэ хэрэгтэй нэгэн зэрэг Панамын хуудсуудаар ил болсон Монголын 40 гаруй хүний оффшор данстай холбоотой асуудлыг нэн даруй шийдвэрлэх ёстой. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс тэдэнд 49 хоногийн хугацаа өгөөд байгаа. Энэ дээр шийдвэртэй ажиллахад Төрийн тэргүүн дэмжиж ажиллана" хэмээсэн юм.

**Оффшорын эсрэг гэрээ байгууллаа**

**2017.06.06**

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга сонгуульд нэр дэвшиж байх үедээ буюу сурталчилгааныхаа нээлтийн үеэр АТОЗ-тэй оффшорын эсрэг хамтарч ажиллахаар гэрээ байгуулсан билээ. Тэрбээр гэрээ байгуулах үедээ Ерөнхийлөгч болбол оффшорын эсрэг тэмцэнэ. Цаашлаад оффшорт байгаа мөнгийг эх орондоо оруулж ирэхийн төлөө ажиллана хэмээн мэдэгдэж байсан билээ. Тиймдээ ч ажлаа авсан даруйдаа л оффшортой холбоотой асуудлаар уриалга гаргасан юм.

**Ерөнхийлөгч оффшор данстай холбоотой уриалга гаргалаа**

2017.07.24

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга улстөрчид, төрийн албан хаагчид, тэдний хамаарал бүхий этгээдүүдэд хандан оффшор данстай холбоотой асуудлаар уриалга гаргасан билээ. Энэхүү уриалгад "Монголын нийгэмд хурцаар шүүмжлэгдэн хэлэлцэгдэж байгаа олон асуудлын нэг нь улстөрчид, төрийн албан хаагчид, тэдний хамаарал бүхий этгээдүүд оффшор бүсэд данстай байх, авлига, хууль бусаар олсон мөнгө хөрөнгөө татвараас болон хууль хяналтаас нууж байршуулж байгаа явдал билээ. Уг мөнгө нь хэлбэрээ өөрчилж АНУ, ИБУИНВУ зэрэг гадаад улсад үл хөдлөх хөрөнгө болж хувирсан тохиолдлууд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр мэдээлэгдсэн. ОУВС, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас нийт 42 улсыг "оффшор бүс" хэмээн тооцож нэрлэсэн байна. Эдгээр оффшор бүс дэх банкуудад Монгол Улсын 49 иргэн данстай байгаа талаар Олон Улсын Эрэн Сурвалжлах Сэтгүүлчдийн Консорциум мэдээлээд байгаа юм. Төрийн өндөр албан тушаал хашиж байгаа хүмүүс, улстөрч, төрийн албан хаагчид, тэдний хамаарал бүхий этгээдүүд оффшор дансанд мөнгөн хөрөнгөө байршуулах нь тухайн хөрөнгийн гарал үүсэл хууль ёсны эсэх, татвараа шударгаар төлсөн эсэх, хөрөнгө орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлсэн эсэх зэрэг олон эргэлзээг бий болгож, шударга ёсонд итгэх олон нийтийн итгэлийг бууруулж байна. Монгол Улс 2017 оныг хүртэл оффшор бүсэд данс эзэмших асуудлаар хууль, эрх зүйн ямар нэгэн зохицуулалтгүй явж ирснээс улбаалан улстөрчид, төрийн албан хаагчид, тэдний хамаарал бүхий этгээдүүд оффшорт данс эзэмшсэн тохиолдлууд байгаа тул олон улсад мөрддөг жишгээр эхний удаад тэдэнд ууч сэтгэлээр хандаж, оффшор данснаас нэн даруй мөнгөө татаж, Монгол Улсдаа оруулж ирэхийг уриалах нь зүйтэй хэмээн үзэж байна. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга миний бие оффшор бүсэд данстай улстөрчид, төрийн албан хаагчид, тэдний хамаарал бүхий этгээдүүдэд хандан 2017 оны долдугаар сарын 24-ний өдрөөс хойш 49 хоногийн дотор оффшор дансаа хааж, тэнд байршуулсан мөнгөн хөрөнгөө Монголын банкинд оруулж ирэхийг уриалж байна. Дурдсан хугацаанд Монголын банкууд руу татагдаагүй мөнгөн хөрөнгө, түүнийг эзэмшигчдийн асуудлыг холбогдох хуулийн дагуу илрүүлэн илчилж, зохих хариуцлага хүлээлгэх нь шударга ёсонд нийцнэ хэмээн үзэж байна" хэмээн дурьдсан юм.

**Сэтгүүлчийн өнцөг**

# УРИАЛГА ТООСОНГҮЙ, ОДОО ЖААХАН ХАТУУХАН ҮЗЭХ ХЭРЭГТЭЙ БАЙНА

Н.ПУНЦАГБОЛД

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ажлаа эхлэхтэй зэрэгцээд л 60 тэрбумын асуудал болоод оффшор данстай нөхдүүдтэй хатуу тэмцэхээ илэрхийлсэн. АТГ болоод бусад хууль хяналтынхантай уулзаж, энэ талаар хэлж, сануулсан. Цаашлаад оффшор бүсэд мөнгө төгрөг аваачиж хадгалсан, нуусан хүмүүст хандаж уриалга хүртэл гаргаж, 49 хоногийн хугацаа өгсөн билээ. Энэ хугацаанд нуусан мөнгө төгрөгөө аятайхан оруулж ирээд, асуудлаа зохицуулахыг сануулсан хэрэг. Тэгвэл Ерөнхийлөгчийн уриалгын хугацаа дуусгавар боллоо. Гэвч энэ хугацаанд гаднаас мөнгөө оруулж ирсэн нэг ширхэг хүн байгаа талаар мэдээлэл гарсангүй. Магадгүй оффшор бүсээс мөнгөө оруулж ирсэн хүн байж болох. Тэр талаар нийтэд мэдээлээгүй ч байж болно. Гэхдээ АТОЗ-ийн тэргүүн С.Батчулуун энэ сарын 5-нд мэдээлэл хийхдээ 49 хоногийн хугацаа дуусах дөхөж байхад мөнгөө оруулж ирсэн хүн алга гэж хэлж байсан. Тийм болохоор хэн ч энэ уриалгыг тоосонгүй гэж хараад байна. Ер нь бол оффшор бүсэд мөнгө аваачиж нуусан хүмүүсийн ихэнх нь улстөрчид. Тэд авлига, хээл хахууль авч, Монгол Улсыг хохироож байж хураасан бохир мөнгөө л оффшор бүсэд аваачиж нууж байгаа нь тодорхой. Ерөөс дэлхий нийтэд тийм л байгаа юм билээ. Харин манайхаас бусад орон оффшор данстай, улс орныг хохироосон хүмүүстэйгээ хатуу тэмцэж байгаа. Хамгийн ойрхон урд хөршийн жишээг ч дурьдаж болж байна. Харин манайх саяхныг болтол тэмцээгүй. Оффшор бүсэд мөнгөтэй хэмээн нэр нь дурьдагдсан хүмүүс худлаа гэж мэдээлэл хийгээд л гүйцээ. Зарим нь бүр албан тушаалаар шагнуулж байх жишээтэй. Харин Ерөнхийлөгч энэ бүхэнтэй тууштай тэмцэхээ илэрхийлж, сануулга өгсөн. Хууль хяналтын байгууллагын дарга нарт ч сануулсан. Дээрээс нь Монголы Улсын Засгийн газар Бахамын болон Маршаллын арлууд, Бүгд Найрамдах Панам Улс, Пуэрто-Рико, Микронезийн Холбооны Улс зэрэг 50 гаруй улсын нутаг дэвсгэрт оффшор данс нээх, мөнгө хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулахыг хориглолоо. Энэ журам хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг төрийн өндөр албан тушаалтан болон түүний хамаарал бүхий этгээдэд хамаатай. Тиймээс одоо нэгэнт эвтэйхэн шийдэхээр хугацаа өгөөд байхад авч хэлэлцэхгүй байгаа бол хатуухан л үзэхээс өөр арга үлдэхгүй нь бололтой. АТОЗ-ийнхөн хэрвээ 49 хоногийн хугацаа дуусах хүртэл нэг ч хүн хөдлөхгүй бол тэрбум ам.долларын хөдөлшгүй, няцаагдашгүй баримтыг Ерөнхийлөгчид өргөн барина гэдгээ мэдэгдсэн. Өнөө, маргаашийн дотор өгөх байх. Тэр дагуу цаашид ямар арга хэмжээ авахаа Ерөнхийлөгч шийдэх биз ээ. Тэгээд хөдөлшгүй, няцаагдашгүй баримт байгаа бол асуудал бүр ч тодорхой болж, хатуухан арга хэмжээ авч эхлэх байлгүй. Манай улс л гэхээрээ эрх мэдэлтэй, албан тушаалтай хүмүүст нь хууль үйлчилдэггүй, хэн ч байсан дураараа авирлаж байдаг цаг одоо улирах цаг ирсэн гэж итгэж байна. МАН-ын бүлгийн гишүүд ч сая шударга ёсыг шаардаж, далдуур хуйвалдан, улсын өч төчнөөн тэрбум төгрөгийг завшиж байгаа үйлдлийг зогсоохоор Засгийн газраа огцрууллаа гэж харж байна. Нэг шалтгаан нь энэ байсан гэж итгэж байгаа. Тийм болохоор тэд ч гэсэн хууль бус, шударга бишийн эсрэг тэмцэх байх. Угаасаа манай улстөрчид өч төчнөөн жил юу дуртайгаа хийгээд, хуйвалдаад, завшаад, улсаа хохироогоод, баялгаа зараад, уул овоо шиг их мөнгө олоод сурчихсан болохоор уриалга төдийг тоохгүй байх. Оффшортоо хэчнээн ч төгрөгтэй, ам.доллартай байсан хөдлөхгүй л гэж бодож байгаа. Байдал эвгүйтэх дээрээ тулбал хэний ч ам руу мөнгө цутгана гэж сэтгэж байгаа байлгүй. Тийм болохоор жаахан хатуу л үзэх хэрэгтэй байна даа. Тэрбумаар яригдах ам.доллар оффшор бүсээс ороод ирдэг юм бол бид өрөө төлөх гэж тэвдэхгүй л болох байх.

# ОРОН НУТАГ

Аймгаас мэдээлж байна

СЭЛЭНГЭ АЙМАГ

## Монголын музейчид Сэлэнгэд чууллаа

Монголын музейчдын “Музей ба хөгжил-2017” чуулга уулзалт Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар суманд боллоо. Чуулганы эхэнд Монгол Улсын 38 музейн 380 гаруй музейчид Партизаны талбай дахь Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөж хүндэтгэл үзүүлсэн юм. Харин үүний дараа Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио” чуулгад Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын дарга Г.Эрдэнэбат тэргүүтэй албаны хүмүүс, зочид төлөөлөгчид цуглан чууллаа. Соёл, урлагийн газрын даргын дарга Г.Эрдэнэбат “Санхүүгийн нөхцөл байдал сайнгүй байгаа энэ цаг үед өөр өөрсдийнхөө нөөц боломжид тулгуурлан шинийг санаачилж, хүмүүсийг музей рүү татах шинэ содон үйл ажиллагааг олж хэрэгжүүлж, байр байшин, мөнгө төгрөг байхгүй гэсэн сэтгэлгээг хоёрдугаарт тавьж ажиллах ёстой” гэдгийг тодотгож, чуулганы үйл ажиллагаанд амжилт хүслээ. Мөн энэхүү чуулганыг аймаг орон нутагтаа зохион байгуулж байгаа Сэлэнгэ аймгийн удирдлагууд, Л.Бямбаа даргатай аймгийн Нэгдсэн Музейн хамт олонд талархал илэрхийлэв. Өмнөх жилүүдэд урлаг, спортын наадам хэлбэрээр голлон зохион байгуулагддаг байсан тус чуулга уулзалтыг Сэлэнгэ аймаг олон улсын эрдэм шинжилгээний бага хуралтай хамтатган зохион байгуулсан нь онцлог байв. Чуулга уулзалтад оролцсон АНУ, ОХУ-ын соёлын өв судлаачид гурван хэсэгт мэргэжлийн чиглэлээр зохион байгуулагдсан салбар хуралдаануудад өөрсдийн орны сайн туршлагаас хуваалцлаа. Сэлэнгэ аймагт зохион байгуулагдаж байгаа “Музей ба хөгжил-2017” музейчдын чуулга уулзалтын зорилго харилцан биенээсээ туршлага солилцох, алдаа оноогоо ярилцах, бусад улс орны дэвшилтэт сайн үйл ажиллагааг нутагшуулан нэвтрүүлэхэд оршиж байв. Мөн урлаг, спортын бага наадам Гүннуур зусланд болжээ.

ДОРНОГОВЬ АЙМАГ

## Эрдэнэ суманд гурван давхар орон сууц барихаар боллоо



Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ард иргэд хямд үнэтэй, тохилог орон сууцанд аж төрөх боломж бүрдлээ. Тодруулбал, Дорноговь аймгийн Засаг мөрийн хөтөлбөрт бага дунд орлоготой болон зорилтот бүлгийн хэрэгцээнд зориулсан орон сууцыг барьж ашиглалтад оруулах зорилт тусгасан юм. Тэгвэл тус зорилтын дагуу УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан, аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин, Төрийн орон сууцны корпорацийн захирал Ж.Хичээнгүй нар “Дорно-999” төслийг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээ байгуулсан байна. Гэрээгээр Эрдэнэ суманд гурван давхар 27 айлын орон сууц барьж, энэ онд багтаан ашиглалтад оруулахаар тохиролцжээ. Орон сууцны ам метр талбайн үнэ 700000 төгрөг байх аж. Дашрамд дурдахад, Эрдэнэ суманд төвлөрсөн халаалтын зуухыг энэ онд барьж эхлээд буй.

## Замын-Үүдэд 15 мвт-ын цахилгаан станц барина

Япон Улсын “Шигемицу шожи” ХХК, “Шарп” корпорац Монголын “Наран тээг” ХХК-тай хамтран Замын-Үүдэд 15 мвт-ын цахилгаан станц барихаар болжээ. Цахилгаан станц ашиглалтад орсноор жилд 28 сая кВт.ц цэвэр эрчим хүч үйлдвэрлэх аж. Мөн 833.150.0 тонн хүлэмжийн хийг бууруулж, 685.750 тонн түүхий нүүрсийг хэмнэж, 5.05 сая тонн цэвэр ус хэмнэхээс гадна 25 хүнийг байнгын ажлын байраар хангах аж.

“Зү гэгээн” нэртэй 15 МВТ-ын хүчин чадалтай нарны цахилгаан станцын шав тавих ёслол энэ сарын 05-нд Замын-Үүд суманд болсон. Шав тавих ёслолд Эрчим хүчний сайдын зөвлөх Ц.Баярбаатар, Эрчим хүчний яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга С.Цэрэнжамц, Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин, Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч Д.Бассайхан, “Шигемицу шожи” компанийн ерөнхийлөгч Гэгээнтана, Замын-Үүд сумын удирдлагууд оролцов.

ОРХОН АЙМАГ

## “Хүүхэд харах үйлчилгээ”-ний 14 төв ажиллана

Орхон аймагт хоёр настай гурван хүүхэд тутмын нэг нь цэцэрлэгт хамрагдаж чадахгүй үлддэг байна. Өөрөөр хэлбэл, 2017-2018 оны хичээлийн жилд тус аймгийн 300 гаруй хүүхэд гэртээ хүмүүжихээс өөр сонголтгүй гэсэн үг юм.

Энэ хичээлийн жилд улсын 24 цэцэрлэгт 1800 хүүхэд орохоор бүртгүүлснээс 70 хувь нь хамрагджээ. Гэхдээ бүртгүүлсэн гэх 300 хүүхдийн зарим нь шилжсэн, хөдөө эмээ, өвөө рүүгээ явсан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байгаа ажээ. Энэ талаар БСУГ-ын СӨБ хариуцсан мэргэжилтэн Л.Тайвантуул “Энэ сарын 20-ны өдрөөс хойш Орхон аймгийн хэмжээнд СӨБ-д хамрагдсан хүүхдүүдийн статистик судалгаа гарна. Цэцэрлэггүй үлдсэн 300 гаруй хүүхэд “Хүүхэд харах” болон хувийн цэцэрлэгт явах боломжтой” гэлээ. Тус аймагт “Хүүхэд харах” үйлчилгээний 14 төв ирэх долоо хоногоос ажиллана.

# А.ӨНӨРЖАРГАЛ: В вирусын хүүхдэд вирус халдварлахгүй

*Монгол Улс улаан хоолойн хорт хавдраар дэлхийд дөрөвт, ходоодны хорт хавдраар хоёрт, элэгний хорт хавдраар нэгт жагссан бөгөөд энэ нь дэлхийн дунджаас найм дахин их байгааг эмч, мэргэжилтнүүд хэлж буй. Сүүлийн үед элэгний вирустай иргэдийн тоо нэмэгдэж, тэр хэрээрээр элэгний хатуурал, хорт хавдраар өвчлөх нь ихэссэн. Тэгвэл элэгний өвчлөлийг бууруулах зорилгоор Орхон аймгийн ЗДТГ, “Эрдэнэтийн эрүүл иргэн ” ТББ хамтран “Элэгний вирусгүй Эрдэнэт хот” аяныг 2016 оны есдүгээр сараас эхлүүлсэн билээ. Энэ талаар Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн А.Өнөржаргалтай ярилцлаа.*

**-Монгол Улсын Засгийн газар энэ оны дөрөвдүгээр сарын 12-ны өдөр “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг баталж, орон даяар хэрэгжүүлж эхэлсэн. Орхон аймаг энэхүү хөтөлбөрийн хүрээнд хэрхэн ажиллаж байна вэ?**

-“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр 2017 оны гуравдугаар сард батлагдсан. Улс орон даяар тавдугаар сарын 05-нд нээлтээ хийсэн. Бид ч Орхон аймагтаа үндэсний хөтөлбөрийн нээлтийг хийсэн. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 40-65 насны хүмүүсийг В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамруулж, илэрсэн тохиолдолд тоолж, эмчилгээ хийх ёстой. Яг энэ үйл ажиллагааг орон нутагтаа өрхийн эмнэлэг, бүсийн оношлогоо эмчилгээний төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай хамтраад хийж байна. Наймдугаар сарын 24-ний байдлаар аймгийн хэмжээнд 40-65 насны 17 мянган иргэн вирус илрүүлэх шинжилгээ хийлгэсэн байна. Энэ нь орох ёстой хүмүүсийн 63 хувь нь гэсэн үг. Шинжилгээнд 12309 буюу 45.2 хувь нь хамрагдсан. Эдгээрээс С вирус илэрсэн нь 16.2, есөн хувьд нь В вирус илэрсэн. Манай аймагт В, С вирусын эмчилгээ хийх эрх бүхий зургаан эмч байдаг. Тэд өвчтөнүүдээ хянаж, шаардлагатай эмчилгээг хийж байгаа. Гэхдээ иргэд маань хэдий эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлт эдэлж байгаа ч, санхүүгийн боломжгүйгээс эмээ авч чадахгүй байгаа учраас эмчилгээнд төдийлөн хамрагдаж чадахгүй байна. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн ажлын хэсэг гарсан. Ажлын хэсгийг аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинжаргал ахлаж байна. Энэ ажиллагаа жаахан удаашралтай байна гээд хоёр удаа ажлын хэсгийг хуралдуулсан. Төрийн болон төрийн бус байгууллагуудад албан даалгавар хүргүүлсэн. Нэгдүгээрт, В, С вирусын илрүүлэг шинжилгээнд ор, хоёрдугаарт, ажилтнуудаа эмчлүүлэхэд нь арга хэмжээ ав, вирус тоолуулахад нь дэмжлэг үзүүл. Ажлын цаг дээр нь ч, эрүүл мэндийн даатгалд хамруулахад нь ч дэмжлэг үзүүл гэсэн утгатай албан даалгаврыг өгөөд есдүгээр сарын 05-нд хэрэгжилтийг нь хянахаар тогтсон.

**-“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр батлагдахаас өмнө Орхон аймаг “Элэгний вирусгүй Эрдэнэт хот” аяныг зарласан. Аян зарлагдаад нэлээд хугацаа өнгөрчихлөө. Аяны хүрээнд ямар ямар ажлыг хийж хэрэгжүүлэв?**

-Манай аймгийн хувьд “Элэгний вирусгүй Эрдэнэт хот” хөтөлбөрийг 2016 оны есдүгээр сараас эхлэн хэрэгжүүлж байгаа. Энэ маань “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрөөс өмнө хийгээд эхэлсэн ажил. Аян маань гурван чиглэлээр явж байгаа. Нэгдүгээрт, элэгний вирусгүй хамт олон болох. Энэ чиглэлийн хүрээнд хамт олонд нь сургалт явуулж байна. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрт 40-65 нас гээд нас заачихсан байгаа. Харин манай “Элэгний вирусгүй Эрдэнэт хот” хөтөлбөрт нас заагаагүй. Ажил хөдөлмөр эрхэлж буй 18-аас дээш насны бүх хүмүүст вирусын илрүүлэгийн шинжилгээг хийж байгаа. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 44 байгууллагын 3094 алба хаагчид эрүүл мэндийн боловсрол олгох сургалт явуулж, элэгний В, С вирусын шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсан. Шинжилгээгээр вирус илрээгүй тохиолдолд вакцинжуулах ажлыг “Элэгний вирусгүй Эрдэнэт хот” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж байна. Энэ хүрээнд В, С вирусын шалтгаант өвчлөлтэй 2116 иргэнийг бүртгэлжүүлж, 522 албан хаагчийг В вирусын сайн дурын дархлаажуулалтад хамруулсан. Ингэснээр 522 хүнийг В вирусын халдвар авах эрсдэлгүй болгож чадсан. Мөн 5941 иргэн элэгний өвчлөл болон амьдралын буруу дадлын талаар эрүүл мэндийн боловсрол олгох танхимын сургалтад, 771 иргэн эхо оношилгоонд, 780 иргэн элэг, цөсний нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт, 2994 иргэн В вирусын дархлаажуулалтад, 4411 иргэн В, С вирус тодорхойлох шинжилгээнд тус тус хамрагдсан. Үүнээс гадна хөтөлбөрийнхөө хүрээнд амьжиргааны түвшин доогуур алслагдсан гэр хорооллын есөн цэгт “Эрдэнэтийн эрүүл иргэн” ТББ, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран ажиллах хүсэлт гаргасны дагуу сургалт явуулсан. Мөн В, С вирусын илрүүлэг шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх вакциныг үнэ төлбөргүй хийхээр болсон. Үнэ төлбөргүй вакциныг 2000 орчим хүнд хийхээр төлөвлөн, ажлаа эхлүүлсэн. Эдгээр вакциныг “Эрдэнэтийн эрүүл иргэн” ТББ, Хавдар судлалын үндэсний төвд санал гаргаад хөнгөлөлттэй үнээр вакциныг авахаар болсон. Вакцины үнийн тал хувийг Дэлхийн зөн байгууллага гарган, дэмжин ажиллаж байна. “Элэгний вирусгүй Эрдэнэт хот” хөтөлбөрийн хүрээнд явуулж буй үйл ажиллагааг “Эрдэнэтийн эрүүл иргэн” ТББ голлох үүрэгтэй зохион байгуулж байгаа юм. Аймгийн Засаг даргын Тамгын газар, эрүүл мэндийн байгууллагууд дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллаж байна. Саяхан “Эрдэнэтийн эрүүл иргэн” ТББ, аймгийн Засаг даргын Тамгын газар, “Медипас” эмнэлэг, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын Ерөнхий газар, “Омбол” ТББ-тай хамтран ажиллах гэрээ байгууллж, санамж бичигт гарын үсэг зурсан. Тус санамж бичигт 200 хүнд С вирусын эсрэг эмийг үнэ төлбөргүй өгөхөөр тусгасан. Нийгмийн даатгалд хамрагдсан 200 хүнд С вирусын эсрэг эмийг өгөх ажил маань одоо эхлэх гэж байна. Учир нь нийгмийн даатгалд иргэдийн хамрагдалтыг сайжруулах зорилгоор ийм шалгуурыг оруулж өгсөн юм. Цаашид энэ үйл ажиллагаа үргэлжилнэ.

> ...Насны хязгааргүй. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрт 40-65 насны иргэнийг үнэ төлбөргүй В, С вирусын илрүүлэг шинжилгээнд хамруулна гээд заачихсан байгаа шүү дээ. Харин манай “Элэгний вирусгүй Эрдэнэт хот” хөтөлбөрийн хүрээнд 18-аас дээш насны бүх иргэнд орон нутгийн төсвөөс хөрөнгийг нь гаргаад илрүүлэг шинжилгээнд хамруулж байна...

**-Элэгний вирустэй эхээс төрсөн нярайд вакцин хийдэг болсон гэж сонссон. Энэ ямар учиртай вакцин юм бэ?**

-Өнгөрсөн гуравдугаар сард “Элэгний В вирусын халдваргүй нярай” төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ төсөл нь “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд батлагдаж, орон нутгийн төсвөөс 35 сая төгрөг төсөвлөсөн. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд элэгний В вирусын халдвартай эхээс төрсөн хүүхдэд 24 цагийн дотор В вирусын вакцин тарих юм. Үүнтэй хамт иммуноглобулин хийнэ. Ингэхээр вирусын халдвартай эхээс хүүхдэд вирус халдварлахгүй болно гэсэн үг. Орхон аймагт жилд 2000 орчим эх төрдөг. Үүний 10 гаруй хувь нь В вирусын халдвартай байдаг гэсэн судалгаанд үндэслэн 300 нярайд хийнэ гэсэн тооцоог гаргасан. Улс дөнгөж үндэсний хөтөлбөрөө батлаад улсын төсөвт хөрөнгийг нь суулгаагүй бол манай аймаг 2017 оныхоо төсөвт суулгаад бэлтгэл ажлаа бүрэн хангасан. Улаанбаатарт ЭХЭМҮТ болон “Гурван гал” эмнэлэгт эхчүүд хувиараа мөнгө төлж иммуноглобулинтай хавсарч, В вирусын эсрэг вакцинаа хийлгэдэг юм байна. Солонгост бол 500 орчим ам.долларын үнэтэй. Монголд 500 орчим мянган төгрөгийн үнэтэй байдаг гэсэн. Бид хөтөлбөрийн хүрээнд “Эм импекс” компанитай хамтран ажиллаж байна. Тэдний орон нутаг ийм ажил хийж байгаа бол бид дэмжие гээд хөнгөлөлттэй үнээр нийлүүлэхээр болсон. Тэгэхээр иммуноглобулин орж ирэх гэрээ хэлэлцээр хийгдсэн. Вакцинаа хадгалах хөргөгчөө бэлдчихсэн. Дээр нь өрх болон төрөх эмнэлгийн эмч, сувилагч нараа сургалтад хамруулсан. Одоо ЭМЯ-аас бидэнд зөвшөөрөл өгөхөд шууд хийх боломж бүрэн хангагдаад байна.



**-ЭМЯ-д хүсэлтээ өгчихсөн үү. Одоогоор ямар нэг хариу ирсэн үү?**

-Хүсэлтээ өгсөн байгаа. Хавдар судлалын үндэсний төвд мөн хүсэлт гаргасан. Нэгэнт үндэсний хөтөлбөрт тусгагдсан учир энэ ажил хийгдэнэ. Харин ч та нар улсаас өмнө эмийг орон нутгийн төсөвтөө суулгаад бэлтгэлээ хангачихсан байгаа нь сайн хэрэг, дэмжиж байна гэсэн бичвэр ирсэн. Бид “Элэгний вирусгүй Эрдэнэт хот” хөтөлбөрийн хүрээнд 2020 он гэхэд В вирусын халдварыг бүрэн устгана гэсэн том зорилт тавьчихсан байгаа. Энэ хүрээндээ хамт олонд, гэр бүлд сургалт өгч байна. Дээр нь нярайдаа вакцин хийгээд эхэлж байна.

**-В, С вирусын илрүүлэг шинжилгээг Орхон аймгийн бүх эмнэлэг хийж байгаа юу?**

-Тийм. Насны хязгааргүй. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрт 40-65 насны иргэнийг үнэ төлбөргүй В, С вирусын илрүүлэг шинжилгээнд хамруулна гээд заачихсан байгаа шүү дээ. Харин манай “Элэгний вирусгүй Эрдэнэт хот” хөтөлбөрийн хүрээнд 18-аас дээш насны бүх иргэнд орон нутгийн төсвөөс хөрөнгийг нь гаргаад илрүүлэг шинжилгээнд хамруулж байна. Энэ ажилд 15 сая төгрөг төсөвлөсөн байгаа. “Эрдэнэтийн эрүүл иргэн” ТББ өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтраад 5000 хүнийг шинжилгээнд хамруулах зорилт тавьсан. Одоогоор 50 хувьтай байгаа. Ерөнхийдөө 40-өөс доош насныхан гэсэн үг.

**-Нярайн эндэгдэл ямар байгаа вэ. Утаанаас болж эхийн хэвлийд бойжиж буй нярайн уушгины үйл ажиллагаа нь дутуу явагддаг гэсэн. Энэ эмчилгээг танайх хийж байгаа гэсэн үү?**

-Сүүлийн гурван жил сурфактант тариаг хийж байгаа. Энэ тариа өртөг ихтэй учраас эрүүл мэндийн байгууллагуудын эмийн төсөвт суудаггүй. Хүмүүс хувиараа авч

# ОРОН НУТАГ

# халдвартай эхээс төрсөн байх боломжтой



хийлгэдэг. Манай иргэд тэр бүр авч, хийж чаддаггүй байсан. Нярай юунаас болж, эндэж буй шалтгааныг бид судлаад, уушгины үйл ажиллагаа дутмаг, ханиад хүрэх ч юмуу, дутуу хөгжилтэй холбоотой байна гэж үзсэн. Ингээд уушгины үйл ажиллагаа сайжруулах сурфактант тариа байвал бидэнд арга хэмжээ авахад сайн байна гэсэн хүсэлтийн Бүсийн оношлогоо эмчилгээний төв болон Эрүүл мэндийн газартаа тавьсан. Энэ дагуу 2014 оноос эхлээд орон нутгийн төсөвтөө тав, 10 сая төгрөг тусгаад бага бага хэмжээгээр хийгээд эхэлсэн. Энэ оны хувьд 35 сая төгрөг суулгасан. Ер нь бол хангалттай гэж үзсэн. Он гарсаар найман сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеийнхээс нярайн эндэгдэл гурав дахин буурсан үзүүлэлттэй байгаа. Энэ бол сурфактант тариаг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэнтэй холбоотой. Мөн нярайн эмч нарыг хоноход нь орон нутгаас дэмжлэг үзүүлж, санхүүжилт өгч байгаа. Дээр нь шөнө хонодог Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн туслах ажилтнууд, сувилагч, үйлчлэгч, техникийн ажилтнуудыг нэг удаа хооллоход нь орон нутгаас дэмжлэг үзүүлж, 20 гаруй сая төгрөгийг төсөвтөө суулгасан. Энэ олон үйл ажиллагаа, дээр нь өрхийн болон нярайн эмч нарын үйл ажиллагаатай холбоотойгоор манай нярайн эндэгдэл буурч чадсан.

**-Ер нь эрүүл мэндийн салбартаа орон нутгаас нэлээд анхаарч байгаа юм байна. Төрөх эмнэлгийн орчныг ч сайжруулсан гэж байсан?**

-Ер нь бол орчин нөхцлийг нь бүрдүүлээгүй байж, эмч, ажилтнуудыг ажиллаад бай, ажиллаад бай гэж болохгүй. Ажиллах орчин нөхцлийг нь бүрдүүлэх ёстой. Амаржих гэж буй эхчүүдийнхээ ч ая тухтай байх орчин нөхцлийг бүрдүүлэх ёстой. Тиймээс ч төрөх эмнэлэгт орон нутаг болоод улсын төсвөөс иж бүрэн засвар хийж өгсөн. Одоо бусад аймагтаа төдийгүй, улсад жишиг болохоор төрөх эмнэлэгтэй болсон. Өмнө нь дөрөв, таваараа нэг өрөөнд төрдөг байсан бол одоо нэг эх нэг өрөөнд л төрнө. Орчин үеийн эрүүл ахуйн шаардлага хангасан долоон төрөх өрөөтэй болчихсон. Төрчихөөд гартлаа тэр өрөөндөө байна. Нэгэн зэрэг долоон эх төрөх боломжтой. Дотроо дохиоллын системтэй.

> ...Өмнө нь дөрөв, таваараа нэг өрөөнд төрдөг байсан бол одоо нэг эх нэг өрөөнд л төрнө. Орчин үеийн эрүүл ахуйн шаардлага хангасан долоон төрөх өрөөтэй болчихсон. Төрчихөөд гартлаа тэр өрөөндөө байна. Нэгэн зэрэг долоон эх төрөх боломжтой. Дотроо дохиоллын системтэй. Энэ мэт ажлыг сүүлийн хоёр, гурван жилд хийсэн...

Энэ мэт ажлыг сүүлийн хоёр, гурван жилд хийсэн. Ер нь улсын хөгжил эрүүл хүнээс л эхэлнэ. Тэгэхээр эрүүл мэнд, боловсрол руу нь илүү анхаарч байгаа.

**-Энэ онд эрүүл мэндийн салбартаа чамгүй мөнгө төсөвлөсөн гэсэн. Сүүлийн үед хийсэн ажлуудаас онцлохгүй юу?**

-Энэ онд эрүүл мэндийн салбарт хийгдэх 42 арга хэмжээнд 1.3 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн. Зөвхөн тоног төхөөрөмжид гэхэд 600 гаруй сая төгрөг баталсан. Одоогийн байдлаар Жаргалант сумын эрүүл мэндийн төвд ЭХО аппарат, Бүсийн оношлогоо эмчилгээний төвд зүрхний бичлэгийн аппарат хоёр ширхэг, Мэндцэдэн, Мөнхийн гэгээ, Мөнхсүндрэл өрхийн эрүүл мэндийн гурван төвд автомашин авч өгсөн. Ер нь улсын хэмжээнд нас баралтын болон өвчлөлийн тэргүүлэх шалтгаан нь зүрх судасны өвчин байдаг. Тийм учраас зүрх судасны аппарат манайд нэн шаардлагатай байна гэсэн хүсэлт тавьсны дагуу орон нутгаас авч өгсөн. Дахиад бид орон нутгийн дэмжлэгтэйгээр хэлэлцүүлэг хийх гэж байна. Үүнээс гадна гемодиализын аппарат, наркозны аппарат, дижитал рентген аппаратыг авч өгөхөөр болсон. Эдгээр тоног төхөөрөмжийг авах гэрээ, хэлэлцээр нь хийгдчихсэн. Тэгэхээр эрүүл мэндийн чиглэлээр орон нутгийн удирдлагууд үнэхээр сайн анхаардаг. Дээр нь эмч нарт зориулсан "Эмч" хөтөлбөрийг хэрэгжүүлж, эмч нараа сургах, ур чадвараа сайжруулах чиглэлд 126 сая төгрөгийг төсөвт суулгаж өгсөн. Эмч нараа эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. 40-өөс дээш насны хүмүүсийг улаан хоолой, дуран, зүрх судасны гэх мэт нарийн мэргэжлийн шинжилгээнд хамруулсан. Мөн ажиллаж байгаа хүмүүсийнхээ урмыг сэргээхийн тулд амьжиргааны төвшин доогуур таван ажилтандаа гэр олгосон. Энэ мэт ажлыг хийлээ. Үүнээс гадна гадаадын улс оронд орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцахад орон нутгаас дэмждэг. Одоогийн байдлаар дөрвөн хүнд таван сая орчим төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна. Мөн эрүүл мэндийн салбарын хорт хавдартай иргэдэд нэг удаагийн тусламж үзүүлдэг. Энэ ажил маань зөвхөн эрүүл мэндийн салбарынх гэхгүй хорт хавдар туссан хүмүүст тусламж үзүүлэх ажил 2009 оноос эхэлсэн. Нэг удаад 150 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлдэг. Мөнгөний хэмжээндээ бус төр тухайн хүнд сэтгэлзүйн эмчилгээ хийж байна гэсэн утгаар тэр дэмжлэгийг үзүүлдэг юм. Ийм дэмжлэг улс орон даяар байдаггүй. Хорт хавдартай иргэдэд нэг удаагийн дэмжлэг үзүүлдэг дэмжлэгийн сан жилд таван сая байсан одоо бол жилд 50 сая байхаар орон нутаг төсөвтөө суулгаж өгсөн. Мөн химийн эмчилгээг 2015 оноос хойш орон нутагт хийдэг болсон. Химийн эмчилгээнийх нь эмийг орон нутгаас авч өгдөг байсан бол ЭМД-д хамрагдсанаас хойш өгөөгүй байна. Зөвхөн иргэдийнхээ гар дээр мөнгөн хэлбэрээр нь олгох ажлуудыг хийж байгаа.

**-Нийгмийн эрүүл мэндийн төвийг орон нутагтаа бие даалгах тухай яригдаж байгаа гэсэн. Ер нь өвдсөн хойноо биш өвдөхөөсөө өмнө урьдчилан сэргийлэхэд энэ төвийн үйл ажиллагаа чиглэгдэх учиртай гэж ойлгож байна л даа?**

-Орон нутгаас Нийгмийн эрүүл мэндийн төвөө тусад нь биеэ даалгах чиг барьж байгаа. Эрүүл мэндийн сайдын 415 дугаар тушаалд Эрүүл мэндийн газрынхаа бүтцэд ажилла гэж заасан байдаг. Тэгэхээр сайдын тушаалыг өөрчлөөгүйтэй холбоотойгоор энэ асуудал хүлээгдэж байна. Сайдын тушаал гараад ирвэл бид Нийгмийн эрүүл мэндийн төвөө биеийг нь даалгаад өвчилсөн хойно нь бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх тал руу нь илүү анхаарал хандуулна гэсэн чиглэлийг орон нутаг барьж байгаа. Одоогийн байдлаар бэлтгэл хангаад 98 сая төгрөгөөр орон нутгийн төсвөөс эхний хөрөнгө оруулалтаа хийгээд шаардлагатай тоног төхөөржмийг нь гардуулаад өгчихсөн. Мөн 0-1 насны хүүхдээс гадна 1-5 насны сульдаатай хүүхдийн зуны сувиллыг 2008 оноос жил бүр ажиллуулж байна. Жилд 100-150 хүүхдийг зуны улиралд хөдөө агаарт гаргадаг. Орон нутгаас түүнийг нь санхүүжүүлдэг. Хүүхдийн өвчлөл, эндэгдэл буурахад энэ бүхэн зохих ёсны нөлөө үзүүлж байгаа. 10 хоногт агаарт гараад тэнд ажиллаж байгаа хүмүүс, бүх эмчилгээнд орон нутаг тодорхой хэмжээний санхүүжилт өгч байгаа. Дээр нь жирэмсэн, амьжиргааны төвшингөөс доогуур эхчүүдийг амин дэмээр хангахад мөн орон нутгаас дэмжлэг үзүүлдэг. Амин дэмийн дутагдалтай, цус багадалттай жирэмсэн эхчүүдэд ч нэмэлт амин дэмийг өгөхөөр төсөвт суулгаж өгдөг. Ерөнхийдөө бид эх, хүүхдийн эрүүл мэнд, өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд түлхүү анхаарч ажиллаж байгаа.

## Аймгаас мэдээлж байна

ДАРХАН-УУЛ АЙМАГ

### Зорилтот өрхийн хараань бэрхшээлтэй 300 хүүхэд үнэ төлбөргүй шилтэй болов



БНСУ-ын Пусан хотод үйл ажиллагаа явуулдаг "Пусан Донгрэ Ротари Клуб"-ын төлөөлөл өнгөрсөн долдугаар сарын 10-нд Дархан-Уул аймгийн Засаг дарга С.Насанбаттай уулзалт хийсэн юм. Тэгвэл тус уулзалтын хүрээнд өнгөрөгч амралтын өдрүүдэд "Пусан Донгрэ Ротари Клуб"-ын 30 төлөөлөгч Дарханд очжээ.

Тэд Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуульд нэг сая вонын үнэ бүхий ном, техник хэрэгсэл хандивласны зэрэгцээ Дархан сумын 15 дугаар багт иргэдийн санаачилга, оролцоог дэмжсэн төсөлтэй танилцсан байна. Мөн аймгийн Эрүүл мэндийн хоёрдугаар төвийн байранд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт суралцаж байгаа хараа муутай шил худалдан авах боломжгүй зорилтот өрхийн хүүхдүүдэд үзлэг хийн харааны шил тааруулж өгчээ. Энэхүү үйл ажиллагаанд харааны бэрхшээлтэй 300 хүүхэд хамрагдсан байна.

### Ашигт малтмал олборлогчдод хяналт, шалгалт хийв

Дархан-Уул аймгийн Засаг даргын баталсан журмын дагуу Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Прокурорын газар, Цагдаагийн газар зэрэг холбогдох байгууллагуудын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тус аймагт ашигт малтмал олборлож буй иргэд ААН-үүдэд тогтмол хяналт шалгалт хийдэг. Энэ удаад дээрх ажлын хэсэг Шарын гол, Хонгор сумдын нутаг дэвсгэрт хяналт шалгалт хийжээ.

Энэ хүрээнд ашигт малтмал олборлох зөвшөөрөлгүй газруудад алт олборлох зорилгоор техник, тоног төхөөрөмж байрлуулан газар ухсан дөрвөн зөрчлийг газар дээр нь илрүүлсэн байна.

Хууль бусаар алт олборлосон дээрх Аж Ахуй Нэгжүүдийн эзэд нь олдохгүй, ажилчид нь байгууллагынхаа эзнийг мэдэхгүй, мэдсэн ч хэлэхгүй тохиолдлууд хяналт шалгалт бүрт тохиолддог гэнэ. Тиймээс аймгийн Цагдаагийн газраас мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулж, хууль бусаар алт олборлосон эдгээр ААН-үүдийн эздийг тогтоон энэ оны долдугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж буй Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авна гэдгээ мэдэгдлээ. Хамгийн гол нь хууль бусаар алт олборлох нь амь нас эрүүл мэндэд хохиролтой, зориулалтын техникээр бус гар аргаар олборлох, техниктэй хэдий ч зөвшөөрөгдөөгүй газар ашигт малтмалын хайгуулын болон олборлох эрхгүй хувь хүн ААНБ-ууд илэрч байгаа нь байгаль орчныг сүйтгэх зэрэгт сөргөөр нөлөөлж байгааг жил бүрийн шалгалтаар сануулдаг ч биеллээ олохгүй байгаа юм.

ХЭНТИЙ АЙМАГ

### Эсгий зээгт ширмэлээр урласан Нууц товчоог танилцуулна




Эсгий зээгт ширмэлээр урласан 108 метр урт Монголын нууц товчоог энэ сарын 13-нд Сүхбаатарын талбайд олон нийтэд танилцуулахаар болжээ. Бүтээлийг Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын "Хан Хэнтий гар урчууд" ХХК-ийн хамт олон анх санаачлан эхлүүлсэн бөгөөд урлах үйл ажиллагаанд монголчууд төдийгүй Өвөрмонгол, Тува, Буриад, Халимаг, Киргиз зэрэг монгол туургатнууд оролцсон байна. Энэхүү гайхамшигт бүтээлд 108 метр цагаан эсгий, 2000 км зээг, 20000 км метр тэмээний утас, 120 ширхэг тэвнэ, 120 ширхэг зүү, 32 өнгийн 100 гаруй литр будаг, 288 метр нягтруулагч таар, 110 метр цагаан даавуу орсон аж. "Хан Хэнтий Гар Урчууд" ХХК-ийн зураач Д.Нэргүй "Бид бүтээлээ Геннисийн номонд бүртгүүлэхээр материалуудаа зохих газарт нь бүрдүүлж өгсөн. Энэхүү бүтээл нь нэгдүгээрт малын гаралтай түүхий эдээр хийсэн, хамгийн урт утас орсон бүтээл. Хоёрдугаарт, эсгийн дээр урласан хамгийн урт дүрслэх урлагийн бүтээл. Гуравдугаарт, хамгийн олон үндэстэн ястан, иргэд оролцсон бүтээл гэсэн гурван номинацид бүртгэгдэх юм" хэмээн ярилаа. Монгол туургатны уламжлалт гар урлалын нэг төрөл болох зээгт эсгий ширмэлийг хойч үедээ залгамжлуулан үлдээх зорилготойгоор Чингис хааны үеийн ахуй амьдрал, ёс заншлыг энэхүү бүтээлд урласан байна. Мөн Монгол зураг, Монгол үндэсний хээ угалз, Хүннүгийн үеийн буган хөшөө, хадны сүг зураг, монгол ёс заншил болох нүүдлэх, мал маллах, бөөгийн үйл, уран дарханы үйл болон бусад үйл явцыг багтаан харуулснаараа онцлог болжээ.

Монгол Улсын 21 аймгийн 5000 гаруй урлаач, үйлчид 2015 оны арванхоёрдугаар сарын 28-наас энэ оны гуравдугаар сарын 12-ныг хүртэлх хугацаанд буюу жил гаруйн хугацаанд бүтсэн тус бүтээлийг урлах явцад 4000 гаруй хүмүүст зээглэн ширэх оёдлыг зааж сургасан байна.

# ЗАВСАРЛАГА

Улаанбаатарт:



Маргааш

Өдөр +21
Шөнө +6



Нөгөөдөр

Өдөр +24
Шөнө +8

## Өдрийн зурхай

**НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ САРЫН ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ҮХЭР ӨДӨР**

**Үс засуулбал:** *Өлсөж үндаасна.*
**Наран ургах, шингэх:** *06.30-19.13*



Тухайн өдөр тахиа, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, мал арилжих, буг дарах, газрын ам боохоод сайн. Эрдэнийг гадагш өгөх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

"Ном" буланд тавтай морил

# ИХ ГЭРИЙН ЭЗЭГТЭЙ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь №152 дугаарт**

-Бид Ван Дер Мервегийн алмасаар өвөр халаасаа дүүргэж аваад үүр цайхаас өмнө буцах замдаа орно.

-Яаж тэгэх юм бэ?

-Тэр амархан. Сэлүүрээр сэлүүрдэж байгаад чулуун дээгүүр хөвөх өнгөрч, дараа нь далбаагаа босгоод гэрийн зүг буцна.

Жеми туйлын батүнэмшилтэй ярьж байсан болохоор нэн удалгүй Бандагийн бүх эргэлзээ замхрав. Энэ төлөвлөгөөнөөс ямар нэгэн өө сэв олох гэж оролдож үзсэн боловч юм бүхэн дээр Жеми бэлэн хариулж байв. Төлөвлөгөө нь бүтэж болох байлаа. Энэ бол энгийн хялбар болж ирээд биелүүлэхэд мөнгө зардал их орохгүй сайхан төлөвлөгөө. Гагцхүү чин зориг, тэвчээр хатуужил л хэрэгтэй.

-Бидэнд олсон алмасаа хийх том цүнх хэрэгтэй болно доо. Гэж Жеми хэлэхэд Банда инээмсэглэж,

-Хоёрыг аваад явбал яасан юм бэ? Гэжээ.

Хоёул урам зориг дүүрэн инээлдэв.

Дараагийн долоо хоногт нь хоёул ажлаасаа чөлөө авч, хориотой бүсээс 40 миль зайтай газар далайн хөвөөнд байдаг Порт-Ноллот гэдэг жижиг тосгон орхоор үхэр тэргээр гарав. Зорьсон газраа хүрээд ачаа юмаа буулгаж, байдлыг ажиглавал ядуу буурай, жижигхэн тосгон байлаа. Бүдүүлэг хийцтэй пин саравч, төмөр пүнз, хэдэн мухлаг, алслан одсон элсэн хаялганы зурвас. Энд хад чулуу байхгүй болохоор тэнгисийн долгион эрэг өөд зөөлөн давалгаалан ирнэ. Завиар хөвөхөд туйлын зохимжтой сайхан газар ажээ. Энд зочид буудал байсангүй. Нутгийн нэгэн худалдаачин жижиг өрөөгөө Жемид хөлслүүлж, Банда хар арьстны суудаг хороололд очиж суулаа.

-Бид нууцаар сал хийж болох газар олох хэрэгтэй байна. Хэн нэгэн нь биднийг эрх баригчдад ховлон мэдүүлбэл тоогүй юм болно гэж Банда өгүүллээ.

Мөн тэр өдөртөө л хэрэглэхээ больсон хуучин муу агуулах оллоо.

-Энэ чинь боломжийн газар байна. Ажилдаа орох цаг боллоо гэж Жеми хэлэхэд

-Арай болоогүй. Жаахан хүлээе. Нэг лонх виски худалдаж ав хэмээн Банда хэлэв.

-Яах юм бэ?

-Яахыг үзэж мэдээрэй.

Маргааш өглөө нь Жеми дээр нутгийн цагдаа хүрч ирэв. Тэр бол хамар нь нарийхан ягаан судсаар бүрхэгдсэн, харвaас архинд дуртай нь андашгүй махлаг зузаан эр байлаа. Цагдаа орж ирээд Жемитэй мэндлэж,

-Сайн байна уу? Манай тосгонд шинэ хүмүүс ирсэн гэж дуулаад танилцхаар ирлээ. Би цагдаа Мэнди байна гэхэд нь

-Намайг Ян Трэвис гэдэг гэж Жеми өөрийгөө танилцуулав.

-Мистер Трэвис та энэд аялж яваа юу?

-Үгүй. Зарцтайгаа Кэйптаун орж явна.

-Аа... би тэнд очиж үзсэн. Муухай том хот билээ. Бас муухай их чимээ шуугиантай.

-Тийм шүү. Цагдаа та жаахан юм балгах уу?

-Би ажлын цагаар уудаггүй гэж цагдаа Мэнди шийдэж ядан хэсэг алгуурласнаа

-За ер нь ганц удаа ёс алдаж болох юм гэхэд нь үүнийг Банда яаж тааж мэдснийг Жеми гайхан нэг лонх вискигээ гарган,

-Сайхан хэрэг ээ гээд аяганы дундуур хэртэй хийж цагдаад барив.

-Баярлалаа, эрхэм Трэвис. Та өөрөө яах вэ?

-Би ууж болохгүй. Хумхаатай. Тийм болхоор Кэйдтаун орж эмчлүүлхээр явж байна. Танай тосгонд хэд хоног амрах гэж буусан юм. Ийм хол газар явах нь надад хэцүү байна гэсэнд цагдаа Мэнди түүнийг ажиглан хараад,

-Харахад та эв эрүүл хүн байна.

-Миний өвчин хөдөлсөн үед та харсан ч болоосой.

Цагдаагийн аяга хурдан хоосров. Жеми дахин виски хийж өглөө.

-Баярлалаа гээд ганцхан хөнтрөн аягыг хоослон,



-За би явах боллоо. Та тэгээд зарцтайгаа хэд хонох юм уу? Гээд босов.

-Тийм миний биеийг жаахан засрахаар бид замдаа орно.

-За сайн. Баасан гаригт би ирж шалгана гэж цагдаа хэлээд гарлаа.

Жеми Банда 2 тэр шөнөдөө эзгүй агуулахад сал хийж эхлэлээ.

-Банда чи сал хийж үзсэн үү?

-Үнэнээ хэлэхэд огт хийж үзээгүй.

-Би ч бас. Энэ хэцүү болов уу? Гээд 2 эр бие биеэ харав.

Тэр хоёр зах дээрээс тус бүр 50 голланы багтаамжтай 4 хос модон торх хулгайлан агуулахдаа зөөж авчирав. 4 торхийг хооронд нь холбож бэхлээд 4 талаас нь модон хайрцаг барьж хүлэв. Дээд талд нь бас тийм хайрцаг хадав. Банда энэ нэгэн төхөөрөмжийг эргэлзсэн байдалтай харж,

-Сал гэхэд нэг л биш шиг гэхэд нь

-Хүлээж бай. Бид хийж дуусаагүй байна шүү дээ гэж Жеми хариулав.

Тэдэнд банз байхгүй болохоор дээд талыг нь гарын дор дайралдсан модны мөчир, дал модны навч мэтээр хучин, энэ бүхнээ олсон аргамжгаар сайтар даруулж боолоо. Ажил дууссаны дараа Банда дахин хараад,

-Энэ ямарч гэсэн сал биш л байна даа гэлээ.

-Аян замдаа орохын цагт бүгд хэвийн байдалтай байх болно гэж Жеми батлан хэлэв.

Нарийхан модны голоор шураг хийж, хоёр хавтгай мөчрийг сэлүүр болгож ашиглахаар бэлдлээ.

-Одоо бидэнд дарвуул хэрэгтэй. Даруйхан шиг. Өнөөдөр аян замдаа ормоор байна. Маргааш Мэнди цагдаа хүрч ирнэ.

Банда дарвуул оллоо. Орой нь нэгэн том баглаа хөх бүс авчраад,

-Энэ болох уу гэлээ.

-Бололгүй яах вэ. Чи үүнийг хаанаас олоо вэ? Гэсэнд Банда жуумалзан

-Асуугаaад юу хийх вэ? Бидэнд тэртэй тэргүй эвгүй юм их боллоо гэжээ.

Хоёул шураг модонд дөрвөлжин бэхэлж, ийнхүү юм бүхэн бэлэн боллоо.

-Шөнийн 2 цагт, энэ тосгоныхныг бүгдээрээ дуг нойрсондоо дугжирч байхад хөдөлье. Одоо хоёул жаахан амрах хэрэгтэй гэж Жеми хэллээ.

Далайгаар хөвөхийн өмнө сэтгэл нь хөөрөн догдлоод тэр хоёр шөнө шөнө цурам хийж чадсангүй. Шөнө 2 цагт хоёул хуучин муу агуулахын өмнө уулзлаа. Хоёул энэ аялалыг тэсэж ядан хүлээхийн сацуу хоёул айж байлаа. Гуравдахь зам байхгүй.

-Цаг боллоо гэж Жеми хэлэв.

Хоёул тэнгисийн хөвөөнд зогсож байв. Эргэн тойрон нам гүм. Дээр нь хархөх тэнгэр цэлийж, хавирган саран сулхан гэрэлтэнэ. "Яасан сайн юм бэ? Биднийг хэн нэгэн хүн олж харах боломж багасна" хэмээн Жеми боджээ.

Тэдний өмнө харанхуй шөнөөр хэнд ч мэдэгдэлгүй далайд гарч, дараачийн шөнө алмаст эрэгт хүрч, үүр цайхаас өмнө буцах замдаа орох хүнд хэцүү зорилт тулгарч байлаа.

-Бенгалын урсгал өнөө орой тийшээ биднийг алмаст хаялганд урсгаж аваачина. Нар жаргаагүй байхад бид тэнд бууж болохгүй. Харанхуй болтол тэнгист хүлээх хэрэгтэй болно гэжЖемийг хэлэхэд Банда толгой дохиж,

-Эрэг орчмын жижиг арлууд дээр нуугдаж болно.

-Юун арал вэ?

-Тэнд Меркури, Икабод, Цөцгийтэй боов... гэх мэт хэдэн арван эзгүй арлууд бий.

-Цөцгийтэй боов оо? Гэж Жеми гайхан лавлахад

-Тэнд Хайрсан махны арал бий гээч

Жеми үнгэгдсэн газрын зураг гарган үзэж эхлэлээ.

-Энд нэг ч арал алга байна.

-Энэ бол сангасан арлууд. Англичууд сангасыг бордоо болгож ашигладаг юм.

-Тэнд хүн бий юу?

-Үнэр танар нь хүн тэсэхийн аргагүй. Зарим газар сангасын зузаан нь 100 фут хүрнэ. Засгийн газар сангас цуглуулахад хоригдлуудыг ашигладаг. Зарим үхэж, хүүр нь тэндээ үлддэг.

-Тэнд чинь бид нуугдана гэж Жеми хэллээ.

Хоёр эр чимээ шуугиан гаргахгүйг хичээн агуулахын үүдийг онгойлгож салаа өргөх гээд байрнаас нь хөдөлгөж дийлсэнгүй. Жеми Банда 2 хар хөлсөө гоожуулан зүтгэвч сал нь ургасан хад шиг байлаа.

-Хүлээж бай гэж Банда хэлээд агуулахаас яаран гарч, хагасцагийн дараа том бөөрөнхий мод чирч ирлээ.

-Ингэж нэг оролдоод үзье. Би салны захаас өргөж байя. Чи үүнийг доогуур нь шургуул.

Банда салны захнаас өргөхөд түүний хичнээн их тэнхээтэйг Жеми гайхав. Тэгээд салны доогуур том бөөрөнхий модыг бушуухан шургууллаа.

**Үргэлжлэл дараагийн дугаарт...**

## Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

Khandmaa Ochir



"Флаш" хамтлаг ид од болж байсан үе. Би фэн нь байлаа. Зурагтаар нөгөө айхтар уйлдаг клифтэй дуу нь яваад, би ч хамгийн чанга дээр нь тавиад дагаж дуулаад сүйд болж байв. Гэтэл ээж гаднаас найзтайгаа цуг орж ирээд "Өө, манай охин мемори хамтлагийн улаан фэн" гээд л хаясан. Яах вэ, дөхүүлсэн л байгаа биз дээ. Ээжүүд буруу зөрүү хөөрхөн юм их ярьдаг шүү...кккк.

